

НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ

Бодлого боловсруулах үйл явцад оролцох

ИРГЭДИЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2009 он

**НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ
Бодлого боловсруулах үйл явцад оролцох
иргэдийн гарын авлага**

Гарын авлагыг бэлтгэсэн баг:

ТРОЙ СОННЕНБЕРГ
АНУ-ын Хавайн Их сургуулийн Төрийн удирдлагын тэнхим
Д.ЭНХЦЭЦЭГ
Нээлттэй Нийгэм Форум

Редактор

Ц.ОЮУНГЭРЭЛ
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
ДИК ПРАТТ
АНУ-ын Хавайн Их сургуулийн Төрийн удирдлагын тэнхим

© Нээлттэй Нийгэм Форум
Энэхүү гарын авлагыг хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор
хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж олшруулахыг хүсвэл
доорхи хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж-1/5
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

DDC
342.05
H-958
ISBN 978-99962-0-027-4
Монгол Улс
Улаанбаатар хот
2009 он

Хэвлэлийн хуудас 6.4
Хэвлэсэн хувь 1000.

«ADMON» компанид эхийг бэлтгэж хэвлэв.

ГАРЧИГ

Өмнөх үг	5
Гарын авлагыг ашиглах тухай	7
1. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	
1.1 Нээлттэй сонсгол гэж юу вэ?	9
1.2 Хууль хэрхэн бүтдэг вэ? Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл явцын хэдийд нь нээлттэй сонсголыг явуулдаг вэ?	11
1.3 Иргэд нээлттэй сонсголд оролцохын ашиг тус юу вэ?	14
2. НЭЭЛТТЭЙ СОНСГОЛД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ ?	
2.1 Амаар болон бичгээр саналаа ирүүлж танилцуулах	16
2.2 Нээлттэй сонсголд хэн оролцох вэ?	17
3. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ СУДЛАХ	
3.1 Хуулийн төслийг судлахдаа зорилгоо тодорхойлох нь	21
3.2 Хуулийн төслийг хэрхэн олж авах вэ?	23
3.3 Хуулийн төслийг уншиж судлах нь	26
4. ХЭЛЭХ ҮГ, САНАЛАА БЭЛТГЭХ	
4.1 Саналаа цаасан дээр буулгаж эхлэх	30
4.2 Амаар саналаа танилцуулах	30
4.3 Бичгээр саналаа өгөх	34
5. НЭЭЛТТЭЙ СОНСГОЛЫН ӨМНӨ	
5.1 Шалгах хуудас	42
6. НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ ДЭЭР	
6.1 Үг хэлэх дарааллаа бүртгүүлэх	48
6.2 Хуралдаан даргалагчийн зааврыг сонсох	49
6.3 Нээлттэй сонсголын үед баримтлах ёсзүйн дүрмүүд	50
6.4 Үгээ хэлэх, саналаа танилцуулах	51
6.5 Сонсгол зохион байгуулагчдын асуултын хэсэг	52
6.6 Нээлттэй сонсгол зохион байгуулж буй байнгын хороо, ажлын хэсгийн нарийвчилсан хэлэлцүүлэг	54

7. СОНСГОЛЫН ДАРААХ АРГА ХЭМЖЭЭ	
7.1 Тухайн асуудал, хууль тогтоомжид үргэлжлүүлэн хяналт тавих, туршлага багатай бусдадаа туслах	55
7.2 Нээлттэй сонсголын үйл явцад туслалцаа үзүүлсэн хүмүүсдээ талархал илэрхийлэх	56
7.3 Нээлттэй сонсголд оролцсон туршлагаасаа суралцах	56
ХАВСРАЛТ	58

ӨМНӨХ ҮГ

Хууль тогтоох үйл явцад иргэдийн оролцоог хангах нь ардчиллын тулгуур зарчмуудын нэг юм. Нийтийн эрх ашигт нийцсэн, удаан хугацаанд тогтвортой хэрэгжиж чадахуйц хууль боловсруулан гаргахад иргэдийн оролцоо чухал үндэс суурь болдог. Тиймээс энэ зарчмыг Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан билээ. Иргэд ийнхүү Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу төрөөс гаргаж буй бодлого шийдвэрийн талаар санал шүүмж гаргаж, байр сууриа илэрхийлэн оролцох үр дүнтэй арга замын нэг нь нээлттэй сонсгол юм. Нээлттэй сонсгол гэж юу болох, түүнд хэрхэн үр бүтээлтэй оролцох талаар иргэдэд зориулсан гарын авлага бэлтгэн Та бүхэнд толилуулж байна.

Сонгуулийн үр дүнд бүрдсэн төр, засгийн байгууллагууд нь ардчилсан зарчмын дагуу ил тод, нээлттэй ажиллаж чадахгүй бол иргэдийг төлөөлөх үндсэн үүргээ хариуцлагатай биелүүлж байна гэж үзэх боломжгүйд хүрдэг. Ялангуяа, иргэдэд хамгийн ойр байж тэдний төлөө үйлчлэх ёстай хууль батлах үүрэг бүхий байгууллагын хувьд УИХ буюу парламентад энэ асуудал илүү ихээр хамаатай юм. Олон улсын туршлагаас үзэхэд нээлттэй сонсгол нь парламентын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, ашиг сонирхлыг нь хөндсөн аливаа асуудлаар иргэдэд байр суурь, үзэл бодлоо илэрхийлэн оролцох боломж олгодог үйл явц байдаг.

Манай оронд өнөөг хүртэл бодлого боловруулах, хууль тогтоох үйл явцад иргэд, төрийн бус байгууллагуудын оролцох арга зам нь захидал бичих, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, цөөн тооны төрийн бус байгууллага, хувь хүмүүс хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцох зэргээр хязгаарлагдсаар иржээ.

Иргэдийн байнгын, бодит оролцоог хангах анхны дорвитой санал санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч гаргаж, өөрийн санаачилсан хууль, тогтоомж, шийдвэрийн төсөлд иргэдээс санал шүүмж хүлээн авах зорилгоор Иргэний Танхим ажиллуулан нээлттэй хэлэлцүүлэг хийж байхаар болсонд иргэдийн оролцоог эрхэмлэн үздэг Нээлттэй Нийгэм Форум нэн талархалтай байна. Түүнчлэн Улсын Их Хурал ч удахгүй хууль тогтоох үйл ажиллагаагаа илүү нээлттэй болгож, иргэдийн оролцооны албан ёсны тогтолцоо бий болгоно гэдэгт найдаж байна.

Бодлого боловсруулах үйл явцад идэвхитэй, үр бүтээлтэй оролцоход тань дэмжлэг болгож энэхүү гарын авлагад нээлттэй сонсголд иргэд хэрхэн бэлтгэж оролцох, тухайлбал, хууль тогтоомжийн төсөлтэй хэрхэн танилцах, санал шүүмж, байр сууриа хэрхэн бэлтгэх, танилцуулах, нээлттэй сонсгол ямар дэг журмаар явагддаг зэрэг мэдээллийг багтаалаа.

Гарын авлагыг бэлтгэн боловсруулахад Нээлттэй Нийгэм Форумтай хамтран ажилласан Америкийн Нэгдсэн Улсын Хавайн Их Сургуулийн Төрийн удирдлагын тэнхимиийн хамт олонд талархлаа илэрхийлье.

Гарын авлагын талаар санал бодол, шүүмжлэл байх аваас Нээлттэй Нийгэм Форумын хаягаар бидэнд хандахыг уншигч Танаас хичээнгүйлэн хүсье.

*Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал*

ГАРЫН АВЛАГЫГ АШИГЛАХ ТУХАЙ

Монгол Улсын иргэн Та Үндсэн Хуульд зааж баталгаажуулснаар төлөөлөгчдийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах хэрэгт шууд оролцох эрхтэй билээ. Төрийн бодлогыг тодорхойлох гол арга зам болох хууль тогтоох үйл явцад үзэл бодол, байр сууриа илэрхийлэн өөрт олгогдсон эрхийн хүрээнд идэвхитэй оролцох нь ардчилсан орны иргэн болохын хувьд Таны хүлээх нэг чухал үүрэг юм.

Нөгөөтэйгүүр ардчилсан төрийн гол онцлог бол аливаа шийдвэр нь олон нийтийн амьдралаас урган гарсан, тэдний төлөө үйлчилдэг байх явдал бөгөөд бодлого, шийдвэр гаргахад ашиг сонирхол нь хөндөгджэй байгаа иргэд, тэдний төлөөллийг оролцуулах зайлшгүй шаардлагатай. Иймээс ашиг сонирхол, байр суурийн хувьд ялгаатай талуудыг бодлогын үйл явцад оролцуулах нь шийдвэр гаргагчдын зүгээс улс төрийн хүлээцтэй байдал, сонирхогч талуудын хувьд оролцооны соёлыг тус тус шаардаж байдаг.

Энэхүү гарын авлага нь чухамхүү оролцооны соёлд суралцахад иргэн Танд туслах зорилготой төдийгүй олон улс орнуудад хууль тогтоох, санаачлах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болсон нээлттэй сонсгол гэж юу болох, иргэд сонирхсон асуудлаараа хэрхэн саналаа бэлтгэж оролцох талаар дэлгэрэнгүй тайлбарлах болно. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд шинээр байгуулагдаад байгаа Иргэний танхимын нээлттэй хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд оролцоход тань энэхүү гарын авлага тус дэм болно гэж найдаж байна.

Гарын авлагын:

Нэгдүгээр хэсэгт нээлттэй сонсголын тухай танилцуулж, хууль тогтоох үйл явцын ямар үе шатанд түүнийг зохион байгуулж болох, иргэд сонсголд оролцож үзэл бодлоо илэрхийлэх нь ямар ач холбогдолтойг тайлбарлана.

Хоёрдугаар хэсэгт иргэд нээлттэй сонсголд оролцохдоо тодорхой хууль, шийдвэрийн төслийн талаар байр сууриа ямар хэлбэрээр илэрхийлж болох, саналаа бэлтгэж хүргэхдээ юуг анхаарах талаар өгүүлнэ.

Гуравдугаар хэсэгт хууль тогтоомжийн төсөлтэй холбоотой материалуудыг хаанаас олж авах, тухайлбал, сонсгол, хурлын зар, хууль, шийдвэрийн төслийг олж авахын тулд интернэтийг хэрхэн ашиглах, мөн хуулийн төсөл, материалаас өөрийн хэлэх үг, гаргах санал, шүүмжлэлдээ оруулах мэдээллийг хэрхэн олж цуглуулах талаар өгүүлнэ.

Дөрөвдүгээр хэсэгт бичгээр болон амаар саналаа танилцуулахад хэрхэн бэлтгэх талаар тайлбарлаж, зарим загвар жишээг оруулсан ба сонсголд танилцуулах саналдаа хүч нэмэх энгийн агаад үр дүнтэй арга техникийг танилцуулна.

Тавдугаар хэсэгт нээлттэй сонсголд оролцохын өмнө бэлтгэлээ бүрэн хангасан эсэхээ шалгах хуудсыг хэрхэн ашиглах талаар зөвлөнө.

Зургаадугаар хэсэгт хуулийн төслийг хэлэлцэх нээлттэй сонсголын үйл явц, тухайлбал үг хэлэх дараалал, сонсголд оролцохдоо баримтлах ёсзүйн дүрэм журмыг тайлбарлаж танилцуулна.

Долоодугаар хэсэгт хууль тогтоох үйл явцад оруулсан хувь нэмрээ баталгаажуулахын тулд нээлттэй сонсголын дараа юу хийж санаачилж болох талаар зарим санал зөвлөгөөг тус тус багтаасан болно.

1. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1 Нээлттэй сонсгол гэж юу вэ?

Xуль тогтоох, шийдвэр гаргах үйл явц дахь нээлттэй сонсгол гэдэг нэр томъёо олон хүний хувьд шинэ содон санагдаж магадгүй юм. Хамгийн энгийнээр тайлбарлавал сонсгол гэсний учир нь ИРГЭН та төрийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын хэлэлцэх гэж буй тодорхой хууль, шийдвэрийн төслийн талаар байр сууриа илэрхийлж, шийдвэр гаргагч ТАНЫГ СОНСОНО гэсэн санааг агуулж буй юм. Нээлттэй сонсголын үндсэн зорилго нь тухайн шийдвэрлэх гэж буй бодлогын асуудлаар иргэд, байгууллагуудаас санал шүүмжлэл, зөвлөмж хүлээн авч, тэдгээрийг нэгтгэн хууль тогтоомжийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, төрийн бодлогын асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглах явдал юм. Нээлттэй сонсгол нь нэрэндээ дурдсанчлан олон нийтэд нээлттэй үйл явц бөгөөд хүссэн хүн бүр түүнд оролцож байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх, эсвэл санал, тайлбар, нотлох баримтаяа бичгээр ирүүлэх боломжийг олгодог.

Тодруулбал, нээлттэй сонсгол нь энгийн хэлэлцүүлгээс ихээхэн ялгаатай юм. Хамгийн гол нэг ялгаа нь сонсголын явцад аль болох олон хүнд байр сууриа илэрхийлэх боломж олгох үүднээс энгийн хэлэлцүүлгийн үеийнх шиг талууд мэтгэлцэх, харилцан ярилцах, санал бодлоо солилцох боломж байдаггүй. Сонсголд оролцогчид тодорхой журам, дэгийн дагуу, ихэвчлэн хурал даргалагчийн зүгээс оролцох хүмүүсийн тоог харгалзаж тогтоосон хугацаанд багтаан эрэмбэ дараалал, эмх цэгтэйгээр байр сууриа илэрхийлэх хэлбэрээр явагддаг.

Манайд мөрдөж буй хууль, бусад шийдвэрийн төсөл өргөн

Нээлттэй сонсгол нь хууль санаачлах, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын байнгын хороо, комисс, Засгийн газар, Ерөнхийлөгчийн томилсон ажлын хэсгээс зохион байгуулдаг нээлттэй хурал, хэлэлцүүлэг бөгөөд хууль тогтоомж, бодлогын асуудлуудаар санал шүүмжлэл гаргаж, зөвлөмж өгөх боломжийг олон нийт, мэргэжилтнүүд, улсын ба хувийн хэвшлийн холбогдох байгууллагын төлөөлөгчдөд олгодог. Хуулийн төслийг хэлэлцэх нээлттэй сонсголыг гол төлөв хууль тогтоох үйл явцын эхэнд, эсвэл дундуур зохион байгуулдаг нь эндээс цуглуулж авсан мэдээллийг ашиглан төслийг батлагдахаас нь өмнө сайжруулж өөрчлөлт оруулдагтай холбоотой. Ингэснээр тухайн хууль тогтоомж, шийдвэр нь нөлөөлж байгаа төрийн байгууллага, салбар, иргэдийн хэрэгцээ шаардлагыг илүү сайн тусгах нөхцөл бүрддэг.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний Танхимиын өрөнхий зураглал

барих, эцэслэн шийдвэрлэхтэй холбоотой дүрэм журамд одоогоор нээлттэй сонсгол гэсэн нэр томьёо байхгүй. Гэвч иргэд, тэднийг төлөөлөх иргэний нийгмийн байгууллага, бусад сонирхогч талын хууль тогтоох үйл явцад оролцох эрхийг хангах үүднээс хууль санаачлагч тэднээс санал авах, үндэслэлтэй гэж үзвэл хуулийн төсөлд тусгах тухай заалтууд бий. Түүнчлэн “УИХ-ын Чуулганы хуралдааны дэг”-д төр нийгмийн анхаарал, ашиг сонирхлыг хөндсөн төслийг нэгдсэн хуралдаан хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дараа анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө уг төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж олон нийтээс санал авах ажлыг байнгын хороо зохион байгуулж болно гэсэн зохицуулалт байна. Эдгээрээс гадна УИХ-ын байнгын хороод төслийн талаар эрдэмтэд шинжээчид, сонирхлын бүлэг, мэргэжлийн байгууллагын санал сонсох, мэдээлэл авах зорилгоор нээлттэй хуралдаан зохион байгуулж хуралдаанд оролцогчдоос санал, мэдээлэлтэй нь холбогдуулж гишүүд асуулт асуух боломжтой байхаар чуулганы хуралдааны дэгд зааж хуульчилсан болно.

Дээр дурдсан хуулийн заалтуудын хүрээнд бодлогын үйл явцад оролцох иргэдийн эрхийг хангах, эрх ашиг нь хөндөгдөж буй болон сонирхогч талуудын санаа бодол, байр суурийг шийдвэр гаргахаас өмнө сонсох албан ёсны тогтмол суваг механизм бий болгох анхны дорвитой санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс гаргасан

нь Иргэний танхимын нээлттэй хэлэлцүүлэг юм. Иргэний танхимын нээлттэй хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн томилсон ажлын хэсгүүд буюу Ерөнхийлөгчийн зөвлөхөөр ахлуулсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах багийнхан зарлана. Энэ дашрамд дурдахад нээлттэй хэлэлцүүлэг хэмээн нэрлэсэн хэдий ч Иргэний танхимд явагдах хэлэлцүүлгийн үйл явц нь сонсгол хэлбэрээр явагдахаар журамлагдсан байна. Тэгэхээр энэхүү гарын авлагыг та Иргэний танхимын Нээлттэй хэлэлцүүлэгт ашиглах бүрэн боломжтой юм.

Парламент буюу УИХ-ын хувьд нээлттэй сонсголыг байнгын хороо, хуулийн төслийн ажлын хэсгүүд зарлан хуралдуулна. Төрийн бусад байгууллагын хувьд ч шийдвэрийн төсөл боловсруулж бэлтгэдэг ажлын хэсэг, хороо, комисс нь нээлттэй сонсгол зарлан хуралдуулж болно.

1.2 Хууль хэрхэн бүтдэг вэ? Хууль тогтоох, шийдвэр гаргах үйл явцын хэдийд нь нээлттэй сонсголыг явуулдаг вэ?

Нээлттэй сонсголыг ихэвчлэн хууль тогтоомжийн төслийг боловсруулах үед, эсвэл УИХ нэгдсэн хуралдаанаараа төслийг хэлэлцэх шийдвэр гаргасны дараа анхны хэлэлцүүлэг болохоос өмнө холбогдох байнгын хороод, төсөл боловсруулагчид, ажлын хэсэг зарлан явуулна.

Хууль, шийдвэрийн төсөл боловсруулах үе шатанд: Хууль санаачлагчийн зүгээс (Ерөнхийлөгчийн тамгын газар, УИХ-ын гишүүн, эсвэл яам, Засгийн газрын агентлаг, УИХ-ын гишүүд, ажлыг хэсэг) төслөө УИХ-д өргөн барихын өмнө нээлттэй сонсгол зарлан зохион байгуулж болно. Тухайлбал, өмнө дурдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын үндсэн үйл ажиллагаа нь ийм төрлийн сонсгол зохион байгуулахад зориулагдаж буй юм.

Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх үед: Хууль тогтоомжийн төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэсний дараа холбогдох байнгын хороонд шилжүүлж нарийвчлан хэлэлцэж эхэлдэг. Бодлогын үйл явцын энэ үе шатанд нээлттэй сонсгол зохион

Нийгмийн анхаарлын төвд байгаа маргаантай бөгөөд хүн амын томоохон бүлгийн ашиг сонирхлыг хөндсөн хууль, шийдвэрийн төслийг хэлэлцэж байгаа үед хэд хэдэн удаа цуврал маягаар нээлттэй сонсгол зохион байгуулж иргэд, сонирхогч талуудад байр сууриа бүрэн дүүрэн илэрхийлэх боломж олгоно.




Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:

Хоёр. Зорилго, үйл ажиллагааны зарчим

- 2.1. Иргэний танхимын зорилго нь хууль болон дүрэм журам, шийдвэрүүдийн төсөлд иргэд, байгууллагаас санал, шүүмжлэл, нэмэлт өөрчлөлтийн санаа, мэдээлэл хүлээн авах замаар төр, засгийн түвшинд гарах шийдвэрийг сайжруулах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцуулах явдал юм.
- 2.2. Иргэний танхимын бүх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байна.
- 2.3. Иргэний танхимд болох аливаа хэлэлцүүлэг нь тодорхой шийдвэр, баримт бичгийн төслийг үндэслэн шийдвэр гаргахын өмнөх шатанд явагдана. Төсөлд өөрчлөлт оруулах, төслийг шийдвэр болгон гаргахдаа Иргэний танхимд болсон хэлэлцүүлэгт үндэслэнэ.

байгуулах бөгөөд ингэснээр хэлэлцэгдэх хууль тогтоомжийн төслийн талаар олон нийтийн байр суурийг сонсох, таниж мэдэх, нарийвчилсан олон талт мэдээлэл цуглуулж улмаар шийдвэр гаргахад харгалзан үзэх боломж бүрддэг.

Диаграмм 1. Хууль хэрхэн бүтдэг вэ?




* Тодоор тэмдэглэсэн хэсэгт нээлттэй сонсгал явагддаг

1.3 Иргэд нээлттэй сонсголд оролцохын ашиг тус юу вэ?

Сүүлийн жилүүдэд иргэд, иргэний нийгмийн зүгээс төр, засгийн шийдвэр, үйл ажиллагааны талаар мэдээлэл авч оролцох, сонгогдсон албан тушаалтнуудтайгаа шууд холбоотой байх, хууль тогтоомж, төрийн бодлогын чухал асуудлуудаар байр суурь, санал бодлоо дуулган сонордуулах, хамтарч ажиллах идэвхи сонирхол илт нэмэгджээ. Гэвч иргэдийн мэдээлэл авах, оролцох эрхийг хангах механизм хангалттай бүрдээгүй байгаа нь одоогийн тогтолцоонд иргэд Улсын Их Хурлын чуулганыг үзэгчийн журмаар сонирхох, эсвэл сонгогдсон албан тушаалтнуудын амлалт, яриаг сонсохоос цааш хэтэрч чадахгүй байгаагаас тодорхой харагдаж буй юм.

Бусад ардчилсан орны хувьд ч улстөрчид нь ярьж, иргэд нь сонсохоос хэтэрдэггүй дутагдал оршиж байсан бөгөөд энэхүү дутагдлыг засах үүднээс хууль тогтоох системдээ нээлттэй сонсголын механизмыг оруулж өгсөн байдаг.

Нээлттэй сонсгол нь юуны өмнө төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлж, иргэд сонгогдсон албан тушаалтнуудтайгаа шууд харилцах, хууль тогтоох үйл явцад өргөн хүрээтэй оролцох таатай боломжийг нээж өгдөг. Тодруулбал, нээлттэй сонсгол нь оролцогчдод хууль, шийдвэрийн төслийг санааныхаа зоргоор засч сайжруулах, гар бие оролцон нөлөөлөх баталгаа өгдөггүй ч хууль тогтоомжийн төслүүд, төрийн бодлогын асуудлаар үзэл бодол, санаа зовнилоо сонгогдсон албан тушаалтнуудад



шууд хэлж илэрхийлэх боломж олгодог. Үүнээс гадна сонсголын явцад иргэд сонгогдсон албан тушаалтнууд өөрийнх нь эрх ашгийг хөндсөн асуудлаар ямар байр суурь баримталж, хэрхэн ажиллаж байгааг харж тодорхой мэдээлэл, ойлголттой болно. Улмаар тэдгээр албан тушаалтынг дахин сонгох цаг ирэхэд сонгуулийн хоосон амлалтад найдаж бус тухайн улстэрчийг байр сууриар нь дүгнэн сонголтоо хийснээр төр дэх өөрийн төлөөллөө чанаржуулах боломж бүрддэг. Нэг үгээр хэлбэл, өөрсдийнхөө үзэл бодлыг сонгуулт албан тушаалтнуудын үзэл бодолтой харьцуулан дүгнэж, итгэл үнэмшлээрээ хамгийн ойр нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх нөхцөл бүрдэнэ гэсэн үг.

Нээлттэй сонсголын явцад оролцогч өөрөө үзэл бодлоо илэрхийлж, саналаа хэлэхээс гадна бусад оролцогч, тухайлбал, иргэд, төр засгийн төлөөлөгчид, мэргэжлийн хүмүүсийн үнэлгээ дүгнэлт, байр суурийг сонсон тэднээс суралцах, мэдээлэл авах боломжтой харилцан ашигтай үйл явц юм. Ийм учраас зарим хүн нээлттэй сонсголд ажиглагч маягаар оролцож, бусдын хэлэхийг сонсон тухайн асуудлаар ойлголт мэдлэгээ баяжуулах зорилго өвөрлөн ирэх нь олонтаа.

Хамгийн чухал нь иргэд нээлттэй сонсгол зэрэг тайван арга замаар төр, засгийн үйл ажиллагаанд оролцсоноор нийгэмд бухимдал хуримтлагдахаас сэргийлж, харилцан ойлголцсон тогтвортой тайван байдал хадгалагдах боломж бүрдэх юм.

2. НЭЭЛТТЭЙ СОНСГОЛД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ ?

2.1. Амаар болон бичгээр саналаа ирүүлж танилцуулах

Нээлттэй сонсголд оролцогч нь хууль, шийдвэрийн төслийн талаар саналаа амаар гаргахаас гадна бичгээр өгч болдог.

Нээлттэй сонсголд оролцох хүн бүртгүүлэхээсээ өмнө хууль, шийдвэрийн төслийн талаарх саналаа чанартай сайн боловсруулж бэлтгэх, түүнийгээ сонсгол дээр биечлэн очиж танилцуулах цаг хугацаа хангалттай байгаа эсэхийг эргэцүүлж бodoх нь зүйтэй. Жишээлбэл, зарим үед ажил ихтэй, зав чөлөө багатай байх үед сонсгол давхсан тохиож мэднэ. Тийм үед нээлттэй сонсголд заавал биеэр очих албагүй, харин бичгээр саналаа хүргүүлж болдог.

Гэвч оролцогч нээлттэй сонсголд бичгээр саналаа илгээх үү, эсвэл өөрийн биеэр очиж ярьж танилцуулах уу гэж шийдвэхээс өмнө доор тайлбарласан дутагдалтай болон давуу талуудыг нь бодолцож үзэхэд илүүдэхгүй.

Амаар саналаа танилцуулах – Биеэр очиж саналаа илэрхийлэхийн нэг чухал давуу тал нь оролцогч хуулийн төсөл боловсруулагчид, байнгын хороо, комисс, ажлын хэсэгт хандан шууд ярьж, байр суурь, санал шүүмжлэлээ гаргах явдал юм. Ийнхүү биеэр ирж сонсголд оролцох нь бичгээр саналаа явуулснаас илүү ашигтай, давуу талтай боловч бас зарим дутагдалтай тал бий. Тухайлбал, нээлттэй сонсголыг зохион байгуулагчид, хуралдааныг даргалагчийн зүгээс тухайн сонсголд хэдэн хүн оролцож байгаагаас шалтгаалаад оролцогч бүрт тэгш боломж олгох үүднээс үг хэлэх хугацаанд хязгаар тогтоодог. Энэ хязгаар нь ихэнхидээ 4-5 минут байна. Ийм нөхцөлд оролцогч нь хэлэлцүүлж буй хууль, шийдвэрийн төслийн талаар байр сууриа товч тодорхой илэрхийлж, шалтгаан үндэслэлээ цэгтэй тоочин хэлэх үгээ сайтар бодож, төлөвлөх шаардлагатай.

Бичгээр гаргах санал – Өөрийн байр суурь, санал шүүмжлэлээ нээлттэй сонсголын протоколд оруулж албан ёсны болгохыг хүссэн иргэд саналаа бичгээр гаргаж сонсголын зард заасан эцсийн хугацаанаас өмнө ирүүлэх боломжтой байдаг. Бичгээр гаргасан санал нь нээлттэй сонсголд биечлэн оролцож амаар саналаа илэрхийлэхээс бага зэрэг ялгаатай. Нээлттэй

сонсголд биечлэн оролцож байгаа хүмүүсийн хувьд хороо, комисс, ажлын хэсгийн гишүүд асуулт тавьсан тохиолдолд хариулах, өөрийн байр сууриа тайлбарлаж хамгаалах боломжтой байдаг бол бичгээр гаргасан саналыг ийнхүү нэмж тайлбарлах боломжгүй. Иймээс оролцогчийн бичгээр гаргаж буй санал нь уншихад хялбар, санаагаа энгийн үг хэллэгээр, шууд ойлгогдоо илэрхийлсэн байвал зохих ба тавьж буй саналын үндэслэл нь тодорхой байх ёстой.

Саналыг хэрхэн боловсруулж бэлтгэх талаар хойно дэлгэрэнгүй тайлбарлана.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:



Тав. Хэлэлцүүлэгт саналаа ирүүлэх

- 5.1. Хэлэлцүүлэгт оролцогч нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хэлэлцүүлэг зарламагц дараахь хэлбэрээр санал шүүмжлэл, байр сууриа илэрхийлж болно. Үүнд:
 - 5.1.1. “Улаанбаатар, Төрийн ордон, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхим” гэж хаягласан захидааар
 - 5.1.2. Иргэний танхимд ирүүлсэн факсаар
 - 5.1.3. Иргэний танхимын irgen@president.mn электрон шуудангаар ирүүлсэн захидааар
 - 5.1.4. www.president.mn веб сайтад санал ирүүлэх хэлбэрээр
 - 5.1.5. Иргэний танхимд болох хэлэлцүүлэгт биечлэн ирж оролцох хэлбэрээр.

2.2 Нээлттэй сонсголд хэн оролцох вэ?

Хуулийн төслийн талаарх нээлттэй сонсголд хувь хүмүүс дангаараа, эсвэл байгууллагууд төлөөллөө ирүүлж оролцож болно. Хувиараа оролцож байгаа хүмүүс заавал санал хэлэх биш тухайн асуудлаар бусдын байр суурийг сонсох зорилго өвөрлөн ажиглагчийн хувиар оролцох боломжтой. Байгууллагууд (төрийн бус байгууллага, албан байгууллага, бизнесийн байгууллагууд гэх мэт) эсвэл албан бус бүлгүүд (сууц өмчлөгчийн холбоод, иргэдийн сайн дурын түр хороод гэх мэт) төлөөлөх хүнээ сонгон түүгээр дамжуулан байр сууриа нэгтгэн илэрхийлж болно.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:

Гурав. Иргэний танхимын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт

- 3.1. Иргэний танхимын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нээлттэй хэлэлцүүлэг байна. Нээлттэй хэлэлцүүлэг нь оролцогч тал, асуудал оруулагч тал, болон зохион байгуулагчаас тус тус бүрдэнэ.
- 3.2. Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогч нь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг хэлэлцүүлэг даргалагчийн урилгаар оролцуулж болно.

Зургаа. Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчдод урьдчилсан болзол тавихгүй байх зарчим ба хэлэлцүүлэгт оролцох дараалал

- 6.7. Хэлэлцүүлэгт үнэ цэнэтэй мэдээллээр хувь нэмэр оруулж чадах төрийн албан хаагчид, судлаач, шинжээч, гэрч, гадаадын болон судалгааны байгууллагын төлөөлөгчийг урилгаар оролцуулж болно.

Ажиглагч: Нээлттэй сонсголд оролцохын тулд заавал үг хэлэх, бичгээр санал ирүүлэх шаардлагагүй хувь хүмүүс, байгууллагын төлөөлөл ажиглагчаар оролцож болно. Тухайлбал, урьд өмнө нь сонсголд огт оролцож байгаагүй туршлага багатай хүмүүс эхний удаад сонсголын үйл явцыг хөндлөнгөөс ажиглаж, ямар үүрэгтэй оролцохоо сайтар ойлгож авах, туршлагатай хүмүүсээс суралцах нь чухал байж болох юм. Эсвэл хэлэлцэгдэх тодорхой асуудлаар мэдээлэл авч, мэдлэгээ нэмэгдүүлэх хүсэлтэй хүмүүс хуралдааны явцыг ажиглан танхимд сууж болдог. Зарим тохиолдолд сонсголд оролцож үг хэлж саналаа танилцуулахдаа оролцогч сандарч тэвдэх явдал гардаг учраас өөрийгөө дэмжих хүмүүсийг танхимд ажиглагчаар байлгах нь санаа бодлоо төвлөрүүлж тайвшрах, байр сууриа цэгтэй, ойлгомжтой илэрхийлэхэд туслах нь бий.



Хувь хүн: Нээлттэй сонсголд хэн ч оролцох боломжтой. Хүн бүрийн хуримтлуулсан туршлага, мэдлэг нь харилцан адилгүй, түүнээсээ хамаараад үзэл бодол нь ялгаатай байх учир сонсголын үеэр оролцогчдоос гаргаж буй санал бүр үнэ цэнэтэй байдаг. Төрийн

байгууллагаас нээлттэй сонсгол зарлан явуулж байгаагийн учир нь хэлэлцэгдэж буй асуудлаар аль болох олон талт байр суурь, санал шүүмж сонсон, улмаар чанартай бодлого, шийдвэр гаргах явдал гэдгийг ойлгож өөрийнхөө байр суурь, үнэ цэнийг үнэлж оролцох нь зүйтэй.



Нээлттэй сонсголд оролцох гэж буй байгууллагуудад зөвлөх нь

- 1) Нээлттэй сонсголын зар нийтлэгдсэн даруид байгууллага, бүлгээс гаргах санал, байр суурийг нэгтгэн боловсруулах ажлын хэсэг, баг томилох нь зүйтэй. Зар нь ихэвчлэн сонсгол болохоос 2-3 долоо хоногийн өмнө гарах тул олон хүний байр суурийг зөв илэрхийлж нэгтгэсэн сайн санал бэлтгэхэд цаг хугацаа шахуу байдгийг анхаарвал зохино. Тиймээс ажлын хэсэгт орох хүмүүс нь сонсголд өмнө нь оролцож байсан туршлагатай, бичгийн болоод ярих, илтгэх чадвар сайтай байх, түүнчлэн ажлын хэсгийг удирдах зохион байгуулах чадвар сайтай хүнээр ахлуулах нь зүйтэй.
- 2) Ажлын хэсгийн ахлагч хэлэлцэгдэх хууль, шийдвэрийн төслийн талаар байгууллагын ажилтнуудаас саналыг нь авах, шаардлагатай үед гаргасан саналуудтай холбоотой нэмэлт тайлбар авах, харилцан зөвлөлдөх, сонсголын явцын талаар мэдээлэл өгөх, зөвлөмж боловсруулах ажлын уулзалтуудыг зохион байгуулах үүрэг хүлээнэ. Мөн нээлттэй сонсголд санал шүүмжлэл, зөвлөмж оруулах хүмүүс саналаа ирүүлэх эцсийн хугацааг нь тогтоож өгөх зэрэг хариуцлагатай үүрэг хүлээдэг.
- 3) Байгууллага/бүлгийн саналыг авсны дараа нэгтгэн эхний төслийг боловсруулна. Эхний төсөл бэлэн болсны дараа түүнийг байгууллага/бүлгийн гишүүдэд тараан танилцуулж санал шүүмжлэл нэмж гаргах боломж, хугацаа олгох ёстой. Ингээд эхний төслийг хянаж дууссаны дараа саналын эцсийн төслийг боловсруулж заасан хугацаанд багтаан холбогдох нээлттэй сонсголыг зохион байгуулж буй ажлын хэсэг, комисс, байнгын хороонд илгээх ёстой.
- 4) Саналын эцсийн хувилбарыг бэлтгэн гаргасны дараа ажлын хэсгийнхэн түүнийг хуулбарлан байгууллага/бүлгийн бүх гишүүдэд тараах бөгөөд илтгэх чадвар сайтай аль нэг хүнийг сонгож нээлттэй сонсголд оролцож үг хэлэх бэлтгэлээ хангахад нь зохих туслалцааг үзүүлнэ.

Хувиараа оролцож байгаа хүмүүсийн хувьд сонсголд оролцож байгаа байгууллагуудын адил санал зөвлөмж бэлтгэх бэлээхэн туршлагатай хүн хүч, нөөц эх сурвалж байхгүй тул өөртөө л найдахаас өөр аргагүй. Иймээс

мэдээлэл цуглуулж саналаа боловсруулж бэлтгэхдээ сонин хэвлэлийн материал, хэлэлцэгдэх асуудлаар урьд өмнө бичигдсэн тайлан, судалгаа зэрэг гарын доорх эх сурвалжууд олж ашиглан, идэвхи зүтгэл гаргаж тууштай хандах нь чухал.

Байгууллагын төлөөлөгч: Хэлэлцэгдэх хууль, шийдвэрийн төсөл нь тодорхой бүлэг хүмүүс, байгууллагын эрх ашигт хамаатай, сонирхлыг нь хөндөж байгаа бол тухайн байгууллага, бүлгийн төлөөлөл (ТББ-үүд, иргэний нөхөрлөл бүлгүүд, төрийн байгууллагууд) нэгдсэн байр сууриа нээлттэй сонсголд танилцуулах нь элбэг тохиолддог. Ийнхүү байр сууриа нэгдмэл байдлаар илэрхийлэх нь гишүүд дор бүрнээ үг хэлснээс илүү жинтэй тусна гэж үздэг. Заримдаа хүч дээр хүч нэмэх үүднээс саналын дор байгууллагын бүх ажилтан, саналыг дэмжиж буй иргэд гарын үсгээ зурсан байх нь бий.

Байгууллага, бүлэг саналаа бэлтгэж боловсруулж дууссаны дараа хамгийн сайн илтгэх чадвартай нэгнээ сонгон нээлттэй сонсголд үг хэлүүлж саналаа танилцуулдаг. Үг хэлэх хүнийг сонгоходоо илтгэх чадвараас гадна тухайн хэлэлцэгдэх асуудлаар ямар туршлага, мэдлэгтэйг мөн харгалзан үзэх нь зүйтэй.

3. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ СҮДЛАХ

Нээлттэй сонсголд оролцогч хэлэлцэх сэдвээр хэдий чинээ их мэдлэгтэй байна төдий чинээ өөрийн байр суурийг бусад оролцогч, ажлын хэсэг, байнгын хорооны өмнө сайн хамгаалж чадах болно. Тиймээс сонсголд оролцогч нь санал, шүүмжлэл, нэмэлт өөрчлөлтийн санаагаа бэлтгэхдээ **тухайн хуулийн төслийг анхааралтай судлан, уг асуудлын талаар аль болох их мэдээлэл цуглуулах хэрэгтэй.**



Аливаа асуудлыг ул суурьтай судалж үзэлгүй сэтгэл хөдлөлөөр хандах нь таны хэлэх үгийн үнэ цэнийг бууруулаад зогсохгүй бусад оролцогчоо үл хүндэтгэсэн зохисгүй хэрэг болно. Иймд нээлттэй сонсголд оролцохос өмнө хэлэлцэгдэх хуулийн төсөл болоод холбогдох мэдээллийг сайтар үзэж судалсны үндсэн дээр үндэслэл сайтай, батлах нотлох баримт жишээтэй санал гаргахад анхаарах нь зүйтэй.

3.1 Хуулийн төслийг судлахдаа зорилгоо тодорхойлох нь

Нээлттэй сонсголд оролцоход юуны өмнө авч үзэх асуудал буюу хуулийн төслийг:

- эсэргүүцэх үү (бүхэлд нь эсвэл хэсэгчлэн)
- дэмжих үү (бүхэлд нь эсвэл хэсэгчлэн)
- эсвэл төвийг сахин төслийг сайжруулахад шаардлагатай мэдээлэл өгч оролцох уу гэдгээ шийдэх ёстой.

Үүний дараа санал, шүүмжлэл байр сууриа батлах, хамгаалах үндэслэл, гол шалтгаануудаа тодорхой гаргах шаардлагатай. Ингэхээр хуулийн төслийг судлах зорилго нь:

- a/ Байр сууриа тодорхой болгох
- b/ Өөрийн байр сууриа батлах, хамгаалах шалтгаануудыг дараалуулан үндэслэлтэй гаргах, шаардлагатай бол зохих нэмэлт, өөрчлөлтийн талаар санал, зөвлөмж боловсруулахад чиглэдэг гэж ойлгож болно.

Үүнийг цааш нь дэлгэрүүлэн авч үзье:

A. Байр сууриа тодорхой болгох. Нээлттэй сонсголд оролцогч нь хэлэлцэх хууль, шийдвэрийн төслийг судлахдаа хамгийн түрүүнд тухайн хуулийн төслийн зүйл, заалтууд нь өөрт болоод ойр дотных нь бусад хүнд хэрхэн тусч нөлөөлөхийг эргэцүүлж үзэх нь зүйтэй. Мэдээж таны эрх ашгийг хохироож байвал төслийг эсэргүүцнэ, харин ашигтай байвал дэмжинэ гэсэн үг. Түүнчлэн зарим үед таны хувьд чухал гэж үзсэн асуудлыг төсөлд ор тас тусгалгүй орхигдуулсан ч байж болно. Тиймээс та хуулийн төслийг анхааралтай унших явцдаа дараахь асуултуудад хариулах гээд үзнэ үү. Тухайлбал, энэ хууль батлагдвал надад болоод миний эргэн тойронд байгаа гэр бүл, хөрш, ойр дотны хүмүүст яаж нөлөөлөх вэ? Эдгээр хүмүүсийн төрөөс авч байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд яаж нөлөөлөх вэ? Түүнчлэн үр хүүхэд, орон нутгийн амьдрал ахуй, сайн сайхан байдлыг сайжруулахад нөлөөлөх үү? Энэ асуудалтай холбоотой “энэ, тэр” чухал зүйлүүдийг тусгасан байна уу? гэх мэт энгийн асуултуудад хариулт хайх нь байр сууриа тодорхой болгоход тусална.

Б. Өөрийн байр сууриа батлах, гол шалтгаануудаа тогтоох. Нээлттэй сонсголд оролцогч нь хэлэлцэх хуулийн төслийн талаар байр сууриа тодорхой илэрхийлсний дараа гол шалтгаануудаа жагсаан бичиж дэлгэрүүлэн тайлбарлах ёстой. Сонсголын үеэр үзэл бодлоо танилцуулах цаг хугацаа (сонсголын индрээс саналаа танилцуулах үед) төдийгүй орон зай хязгаарлагдмал байдаг (бичгээр санал өгөхөд) учраас олон зүйл нуршин тайлбарлах боломжгүйг санан танилцуулах саналдаа цөөн чухал үндэслэл, шалтгаан дурдаж бүрэн дүүрэн тайлбарлаж танилцуулахад анхаарах нь зүйтэй.

3.2 Хуулийн төслийг хэрхэн олж авах вэ?

Нээлттэй сонсголд оролцохын тулд хэлэлцэх хуулийн төслөөс эхлээд бусад мэдээллийг олж авах зайлшгүй шаардлагатай бөгөөд сонсгол зохион байгуулагчдын зүгээс эдгээр мэдээллийг оролцогчдод аль болох хүртээмжтэй түгээхэд анхаарах ёстой.



Нээлттэй сонсголын зар: Юуны түрүүнд Нээлттэй сонсголд хэлэлцэх гэж байгаа хууль тогтоомжийн төслийн жагсаалтыг буюу сонсголын зарыг олж үзэх ёстой. Зард хэлэлцэх хуулийн төслийг хаанаас авч үзэхийг заасан байхаас гадна нэмэлт мэдээлэл шаардлагатай, асууж тодруулах зүйл байгаа бол харилцах хаяг, утас, цахим шуудан зэргийг дурдсан байдаг (доорх жишээнээс үзнэ үү). Тухайлбал, Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимиын хувьд хуулийн төслийн бүрэн эхийг хэлэлцүүлгийн зар нийтлэгдсэн аль нэг сонинд хэвлэх журам мөрдөж байна (“Нээлттэй сонсголын зар” жишээг харна уу).

Интернэт: Сүүлийн жилүүдэд Интернэт хэрэглэгчдийн тоо өсөхийн хэрээр төрийн байгууллагууд хямд төсөр аргаар олон хүнд мэдээлэл хүргэх ач холбогдлыг нь үнэлэн цахим хуудас идэвхитэй ажиллуулах болсон. Сонсголоор хэлэлцэх хуулийн төсөл болон бусад мэдээллийг www.parliament.mn (25 дугаар нүүрт байгаа вебсайтын зургийг харна уу), www.president.mn, www.open-parliament.mn зэрэг вэбсайтаас хайгаад үзээрэй. Засгийн газар нээлттэй сонсгол явуулах тохиолдолд зар болоод бусад холбогдох мэдээлэл <http://www.open-government.mn> вэбсайтад байгаа эсэхийг үзэхэд илүүдэхгүй.

Хууль, тогтоомжийн төслөөс гадна уг төсөлтэй холбоотой судалгааны тайлан, лавлагаа, тооцоо зэрэг бусад мэдээллийг ч эдгээр вэбсайтаас хайж болох юм.

Сонин хэвлэл: Сонсголоор хэлэлцэх хуулийн төсөл нь нийгмийн анхаарал, ашиг сонирхлыг хөндсөн, маргаантай асуудал бол тухайн сэдвээр сонин хэвлэлд янз бүрийн зүйлс нийтлэгдсэн байх нь олонтаа. Сонин хэвлэлийн материал нь тухайн сэдвээр сонирхогч талуудын баримталж буй янз бүрийн байр суурь, үзэл бодлыг илэрхийлсэн байдаг тул оролцогчдын хувьд маш үнэ цэнэтэй мэдээлэл болох бөгөөд тэдгээрийг ашиглаж санал, шүүмжлэлдээ хүч нэмж болно.

УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвүүд: Орон нутгийн иргэдийн хувьд Интернэтээс мэдээлэл олж авах нь түвштэй, сонин хэвлэл оройтож очих бэрхшээл тохиолдож болно. Иймд 20 аймаг, нийслэлийн долоон дүүрэгт ажиллаж байгаа УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвүүдээс мэдээлэл авах гээд оролдоод үзээрэй. Эдгээр төв нь УИХ-ын үйл ажиллагааг олон нийтэд илүү нээлттэй болгох, УИХ-ын хууль тогтоо болон хянан шалгах ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, энэ талаар УИХ-ын Стратеги төлөвлөгөөнд заасан зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй.

НЭЭЛТТЭЙ СОНСГОЛЫН ЗАР

20... оны 10 дугаар сарын 1-нд Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд “Төрийн одон медалиар шагнах тухай хууль”-ийн төслийг хэлэлцэх нээлттэй сонсгал болно. Сонсгал 20... оны 10 дугаар сарын 1-ний өдрийн ...:00 цагаас ...:00 цаг хүртэл Улаанбаатар хотноо Төрийн ордны зүүн жигүүрийн гуравдугаар давхарт байрлах “Иргэний танхим”-д явагдах бөгөөд сонирхсон хувь хүн, байгууллага, агентлагуудыг өргөнөөр оролцохыг урьж байна.

Бичгээр ирүүлэх саналыг 20... оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөр масалбар болгож дор дурдсан хаягаар болон факс, электрон шуудангаар хүлээн авна. Хугацаа хоцорч ирүүлсэн саналыг нээлттэй хэлэлцүүлгийн тайлан тэмдэглэлд оруулахгүй болохыг анхаарна уу.

“Төрийн Одон Медалиар Шагнах тухай хууль”-ийн төслийн эхийг www.president.mn веб сайт дээр болон сонини 20.. оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дугаарт нийтлэв. Сонсголд биечлэн оролцохыг хүссэн хүмүүсийг 20.. оны 9 дүгээр сарын 28-ны өдөр ажлын найман цагийн турши доорх утас, факс, электрон шуудангаар бүртгэнэ. Мөн өдрийн 9:00-өөс 18:00 цаг хүртэл бүртгэнэ.

Нээлттэй хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээллийг 1234-1234 дугаарын утсаар лавлана уу.

Шуудангийн хаяг: Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний Танхим

Төрийн ордон, Өрөө

Улаанбаатар, Монгол Улс ...-

Факс: 976-...-.....

Электрон шуудан: mttttt@tttt.tnnn

Иргэний танхимын үйл ажиллагааны журам болон “Төрийн одон медалиар шагнах тухай хууль”-ийн төслийг

<http://www.president.mn/civilHall/civil-hall-juram.php> веб хуудаснаас авч танилцана уу.

The screenshot shows a search result for a bill titled "Орон сууц хүснэгт, мөнгөн олгоговор авах хүснэгт ихсэн хандлагатай байна Мэдээ, нийзэлжел > Албан мэдээ" dated 2009/10/20. A callout box highlights the text "Хайж буй хуулийн төслийн нэрийг энд бичээд enter товчийг дарна." (Type the name of the bill in the title line and press enter to select it).

The screenshot shows a list of bills under the heading "Хуулийн төслийн нэмэлт мэдээлэл". One bill is selected: "Төслийн эзэр" (Gender Law) dated 2009/10/12. A callout box highlights the text "Хайлтын үр дүнд тухайн хуулийн төслийн цахим хувь гарч ирэх бөгөөд түүн дээр дарж татаж авах буюу хэвлэж гаргах боломжтой."

Энэ үргийнхээ хүрээнд УИХ-аас батлагдан гарсан хууль тогтоол шийдвэрийг иргэдэд хүргэх, нөгөө талаас УИХ-ын чуулганаар хэлэлцэх хууль, шийдвэрийн



төслийн талаарх иргэдийн санал хүсэлтийг авах, тухайн орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүний үйл ажиллагааг сурталчлах, мэдээлэх үйл ажиллагаа явуулдаг. Сурталчилгааны төвүүд нь нь аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд байрладаг. Таны оршин суудаг аймаг, дүүрэгт ийм төв ажиллаж байгаа эсэхийг www.open-parliament.com цахим хуудаснаас үзэж магадлаарай.

3.3 Хуулийн төслийг уншиж судлах нь

Нээлттэй сонсголд оролцохын өмнө хэлэлцэх хууль тогтоомжийн төслийг анхааралтай уншиж судлах нь чухал. Хуулийн үг хэллэг нь мэргэжлийн бус хүмүүст ойлгоход бэрх санагдах тал бий. Гэвч үүнээс сурдэж урам хугарах хэрэггүй. Хуулийн төсөл уншиж судлахад ашиглаж болох зарим зөвлөгөөг доор танилцуулж байна:

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

- Хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсэг төслийг бэлдэх явцаа Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар гэх мэт холбогдох байгууллагуудтай зөвлөлддөг. Тиймээс эдгээр байгууллагад тухайн сэдэвтэй хамаарах мэргэжлийн мэдээлэл, тооцоо судалгаа байгаа гэдгийг санаж өөрийн санал, шүүмжлэлийг гаргахдаа ашиглах нь зүйтэй. Ингэснээр тухайн сэдвээр илүү өргөн хүрээтэй дүгнэлтэд хүрэх боломжийг олгодог. Төрийн холбогдох байгууллагуудаас мэдээлэл авахад хуулийн албан ёсны нэрийг тавьж хүсэлтээ ихэвчлэн бичгээр гаргах шаардлага тулгарна.

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1. Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн даатгалын хэлбэр, хамрах хүрээг тогтоож, эрүүл мэндийн даатгалд даатгуулж шимтгэл төлөх, эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулахтай холбогдсон даатгалын болон эрүүл мэндийн байгууллага, төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

- **Зорилт=Шалтгаан**

Тухайн хуулийн төслийн Зорилт гэсэн хэсэгт уг хуулийн төсөл бичигдсэн гол шалтгаан, хамрах хүрээг тодорхойлох учраас энэ хэсгийг анхааралтай уншиж шаардлагатай үгнүүдийн доогур зурж тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, энэ хэсэгт эрүүл мэндийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ, даатгуулж шимтгэл төлөх, санг бүрдүүлж хуваарилах, зарцуулах гэсэн хэсгүүд анхаарал татах байна.

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж

2. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

- “Хууль тогтоомж”-ийн хэсэг нь энэ хуультай холбоотой бусад хууль тогтоомжийг хэлж өгдөг учраас маш чухал гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэ хэсэгт дурдсан хуулиудаас зарим зүйлийг тодруулж харах шаардлага урган гарч магад.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

- 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 3.1.1. “даатгалын гэрээ” гэж даатгагчаас даатгуулагч болон эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээг;
 - 3.1.2. “даатгагч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг;

- **Нэр томъёоны тайлбаруудыг унш.**

Хууль тогтоомжийг гол төлөв маш нарийн хуулийн хэллэгээр бичдэг учраас зарим үг, хэллэгүүд оролцогчдод сайн ойлгогдохгүй байж болно. Тэгвэл энэ хэсэгт тухайн хууль тогтоомжид орсон нарийн түвэгтэй үг, хэллэгүүдийг тодорхойлж, тайлбарлаж өгөх болно.

6 дугаар зүйл. Даатгалд хамрагдах хүрээ

- 6.1. Монгол Улсын дор дурдсан иргэн эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна:
 - 6.1.1. аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан;
 - 6.1.2. аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;
 - 6.1.3. 16 (өрөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18) хүртэлх насны хүүхэд;
 - 6.1.4. их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч;
 - 6.1.5. тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн;
 - 6.1.6. хүүхдээ 2 (ихэр бол 3) нас хүртэл нь өсгэн бойжуулж байгаа эх (эцэг);
 - 6.1.7. хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;
 - 6.1.8. малчин;
 - 6.1.9. **Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн;**
 - 6.1.10. ял эдэлж байгаа хоригдол;
 - 6.1.11. энэ хуулийн 6.1.1 – 6.1.10-т зааснаас бусад иргэн.

7 дугаар зүйл. Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ

8 дугаар зүйл. Даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, төлөх журам

12 дугаар зүйл. Даатгуулагчийн тусlamж, үйлчилгээний зардлын төлбөр

- **Хамрах хүрээ:** Хамрах хүрээ нь тухайн хуулийн төсөл хэнд нөлөөлөхийг уншигчид хэлж өгөх бөгөөд хамгийн гол нь та болон танд хамаатай хүмүүст энэхүү хуулийн төсөл нөлөөлөх эсэхийг дурдсан байдаг. Тухайлбал, бүлэг, байгууллагуудын хувьд дараахь зүйлсийг анхаарах шаардлага урган гарна:
 - Энэ хуулийн төсөл манай байгууллагад нөлөөлөх үү?
 - Энэ хэсэгт ямар төрлийн бүлэг, байгууллагыг хамрахаар заасан байна вэ?
 - Энэ жагсаалтад нас, мэргэжил, хүйс болон бусад ямар онцлогийг заасан байна вэ?

- Зарим хүн өөрсдийгөө аль нэг ангилалд хамааруулж ойлгож чадахгүй буюу хамаарах эсэх нь тодорхойгүй байж болно. Тийм тохиолдолд уг хуулийн төсөлд тухайн хуулийн төслийн холбогдо заалтыг буюу энэ мэдээллийг олж авч болох өөр хуулиудыг заасан байна.

- **Дэд гарчгийг анхааралтай уншиж тодруулж тэмдэглэл хий.**
- Эндээс оролцогчид саналаа бичихэд шаардлагатай мэдээллийн дийлэнхийг олж авах болно. Хуулийн төслийг гүйлгэн унших зуураа санал, шүүмжлэлтэй холбоотой зүйл, заалтуудыг тэмдэглэж авч байх хэрэгтэй. Ингэснээр оролцогч эдгээрийг саналаа боловсруулж, бичиж эхлэх үедээ эргээд хялбархан олж болно (Тэмдэглэл хийхдээ олон янзын аргыг ашиглаж болно. Тухайлбал, чухал мэдээлэл агуулсан зүйлүүдийн нэрийг дугуйлж, чухал бус зүйлийн нэрийн дундуур зурж тэмдэглэж болно).

Дагалдах материалыг судлах

Хэрэв сонсголоор хэлэлцэх асуудал, хууль журам, шийдвэрийн төсөл нь барилга байгууламж, хот байгуулалт, уул уурхайн ашиглалт, хайгуулын зөвшөөрөл олгох шийдвэрийн төсөл, бэлчээр хуваарилалтын зэрэг асуудалтай холбоотой байвал уг шийдвэрийг дагалдсан газрын зураг, барилгын зураг төсөл зэрэг нэмэлт материал зайлшгүй байх ёстой. Гэтэл олон материал тухайлбал, кадастрын зураг, газрын зураг зэргийг олон тоогоор олшруулан тараах, хэвлэлд нийтлэх боломж тэр бүр байдаггүй. Ийм учраас та шаардлагатай байгаа материалаа сонсгол зохион байгуулах ажлын хэсэгтэй холбогдож яаж олж авах талаар лавлан туслалцаа хүсч болно. Өндөр хөгжилтэй ихэнх орнуудад ийм тохиолдолд сонсголын өмнө тухайн нээлттэй сонсгол болох танхимд бүтэн сарын турш, заримдаа хоёр долоо хоногийн хугацаанд газрын зураг, зураг төслүүдийг дэлгэн тавьж иргэдэд танилцуулдаг. Шаардлагатай материалаа олоод авсан бол мэргэжлийн хүмүүсээс туслалцаа хүсч тайлбаруулж болох юм. Мөн газар нутаг, уул усаа сайн мэдэх туршлагатай хүмүүстэй зөвлөлдөж болно. Ингэж нэмэлт материалыг сайтар судалсны үндсэн дээр иргэд төслийн талаар байр сууриа илэрхийлэх боломжтой болно.

Асууж сурагла, тусlamж хүс!

Нээлттэй сонсгол буюу, эсхүл сонсголоор хэлэлцэх хуулийн төслийн талаар асууж тодруулах зүйл байгаа бол оролцогчид эргэлзэж тээнэгэлзэлгүй зохион байгуулагч, ажлын хэсэг, байнгын хороо, мэргэжлийн хүмүүстэй холбогдож саналаа боловсруулж бичихдээ туслалцаа авах хэрэгтэй. Нэг мэдээлэл олоод үзэхэд илүү нарийн өөр мэдээллийг хайх шаардлага байнга гардгийг санан оролцогчид хичээл зүтгэл гарган аль болох эрт асууж сураглан мэдээллээ цуглуулж авахад анхаарах нь зүйтэй.



4. ХЭЛЭХ ҮГ, САНАЛАА БЭЛТГЭХ

Нээлттэй сонсгол дээр оролцогчийн хэлэх үг нь бодлого боловсруулагчид, ажлын хэсгийн өмнө байр сууриа илэрхийлж, бодлогод нөлөөлөх хамгийн таатай, шууд боломж юм. Хэлж ойлгуулахыг хүссэн санаагаа цэгцтэй бөгөөд тодорхой илэрхийлж сайтар бэлтгэсэн санал шүүмжлэл нь ажлын хэсэг, төсөл боловсруулагчид, байнгын хорооны гишүүдийн анхаарлыг татаж хүчтэй нөлөө үзүүлдэг. Эсрэгээрээ тааруухан бэлтгэсэн санал нь зохион байгуулагч, оролцогч талуудын үнэтэй цагийг дэмий үрсэн хэрэг болно. Иймээс санал шүүмжлэл, хэлэх үгээ чанартай сайн боловсруулж бэлтгэхэд анхаарч хангалттай цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулах ёстой.

4.1 Саналаа цаасан дээр буулгаж өхлэх

Сонсголд биечлэн очиж үг хэлэх, бичгээр санал илгээж оролцохын саль ч хэлбэрийг сонгосон хуулийн төслийн талаар хэлэх саналаа ямагт цаасан дээр буулгаж ноороглож бэлтгэх нь зүйтэй. Ийнхүү бичиж төлөвлөх нь хэлэх санаагаа улам тодорхой болгох, хуулийн төсөлд өгөх саналын үндэслэл, баталгаа нотолгооны хүчтэй ба сул талуудыг жиших, ач холбогдлын дарааллыг тогтоо зэрэгт тустай байдаг. Цаашилбал санал шүүмжлэлээ цаасан дээр буулгаснаар шаардлагатай засвар өөрчлөлтийг оруулж боловсронгуй болгоход хялбар болно.

4.2 Амаар саналаа танилцуулах

Нээлттэй сонсголд биеэр очиж оролцон санал хэлэх гэж байгаа бол дараахь зүйлсийг санаад илүүдэхгүй:

- Цагаа барих:** Ямар асуудлыг хэлэлцэж байгаагаас шалтгаалаад нээлттэй сонсголд оролцогчдын тоо хэдэн арваас хэдэн зууд хүрэх нь бий. Ийм нөхцөлд саналаа илэрхийлэхийг хүссэн хүн бүрт тэгш боломж олгох үүднээс сонсголыг зохион байгуулагчид, хурал даргалагчийн зүгээс үг хэлэх хугацаанд хязгаар зааж тогтоодог тухай өмнө дурдсан. Үүнийг гол төлөв журамд болон зард анхааруулсан байдаг. Заасан хугацаанаас хэтрүүлэлгүй саналаа хэлэх нь сонсголд оролцогчийн хувьд

хурлыг зохион байгуулагчид болоод бусад оролцогчоо хүндэтгэж буй хэрэг болно.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:

- 8.2. Даргалагч хэлэлцүүлгийн дэгийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хэлэлцэх асуудлын нарийн түвэгтэй байдлыг харгалзан хэлэлцүүлгийн нийт хугацаа, нэг оролцогчийн уг хэлэх хугацааг тус тус тогтооно. Ингэхдээ нэг хүний уг хэлэх хугацааг 3-10 минутаар тогтоож болно.
- 8.3. Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст уг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгох ба ингэхдээ нэг хүн А-4 хэмжээний бүтэн хуудас материал үншиж танилцуулж чадахуйц хэмжээгээр цаг олгоно.

Сонсголыг эмх цэгцтэй явуулахын тулд санал хэлэх хугацаа хэтэрмэгц хурал даргалагч үгийг таслах нь энгийн үзэгдэл байдаг. Ийм тохиолдолд нийт оролцогчдод цагийг жигд хуваарилах нь хурал даргалагчийн үүрэг гэдгийг ойлгож уурлаж уцаарлаж, бүдүүлэг, зохимжгүй уг хэллэг хэрэглэхгүй байх ёстой. Зохион байгуулагчид хурлыг үймүүлж, саад болж буй оролцогчийг хурлын танхимаас гаргах хүртэл арга хэмжээ авдаг болно.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:

- 8.9. Хэлэлцүүлэгт оролцогч зочин бүдүүлэг уг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, яриаг нь таслах, өмнөөс нь уг хэлэх, хашгирах, шүгэлдэх, хөлөө дэвслэх зэрэг бусдын үгээ чөлөөтэй хэлэхэд нь саад учруулсан үйлдэл гаргавал хэлэлцүүлэг даргалагч дэг баримтлахыг шаардах бөгөөд шаардлагыг үл биелүүлбэл Иргэний танхимын Ажлын алба оролцогчийг танхимаас гаргаж болно.

- **Өөрт олдсон боломжийг дээд зэргээр ашиглах:** Нээлттэй сонсгол дээр үг хэлэх ээлж ирэхэд бичгээр бэлтгэсэн зүйлээ үг үсэггүй уншиж болохгүй. Яаруу сандруу уншсан зүйлээс чинь таны хэлэх гэсэн гол санааг хүмүүс сайн ойлгож чадахгүй байж магадгүй. Үүнээс сэргийлэхийн тулд ярих зүйлсийнхээ өрөнхий тойм бүтэц, дарааллыг гаргаж ингэхдээ юуны өмнө байр сууриа тодорхой дурдан, түүний дараа тухайн байр сууриа хамгаалах, батлах, нотлох шалтгаан үндэслэлүүдээ ач холбогдоор нь эрэмбэлэн өгүүлэх нь зүйтэй.
- **Жишээ татах хэлэх үгээ сонирхолтой болгох:** Нээлттэй сонсголын үеэр хуулийн төсөл боловсруулагчид, ажлын хэсэг, байнгын хорооныхны анхаарлыг татах шилдэг арга бол хэлсэн санаагаа бодит жишээ баримтаар “чимэх” арга мөн.
- **Эсрэг талаа няцаах:** Хэлэх үгэндээ эсрэг талын байр суурийг яагаад үндэслэл муутай байгааг нь тайлбарлаж няцаахыг хичээх нь зүйтэй.



АНУ-ын Монтана мужийн парламентын
нээлттэй сонсгол дээр иргэн үг хэлж буй байдал

Амаар танилцуулах саналын өрөнхий бүтэц

ОРШИЛ ХЭСЭГ

Төрийн албан тушаалтанд хүндэтгэлтэйгээр хандан мэндчилж талархал илэрхийлэх

- Эрхэм сонсголыг даргалагч, ажлын хэсгийн эрхэм гишүүдийн өглөөний/өдрийн амгаланг айлтгая.
- “Иргэний танхимд чухал асуудлаар үг хэлэх боломж олгосонд талархлаа илэрхийлье.”

Өөрийн нэрийг хэлж, төвч танилцуулах эсвэл энэхүү чухал асуудалтай ямар холбоотойгоо хэлэх

- “Миний нэрийг _____ гэдэг. Би _____-ээс/-ийг төлөөлж ирсэн.”
- “Миний бие (ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЛБАН ЁСНЫ НЭР)-ийг ДЭМЖИХ ээр саналаа өгч байна.” (эсвэл “ЭСЭРГҮҮЦЭХ-ээр” гэж хэлж болно)
- Хуулийн төсөлд дараах чухал асуудлуудыг нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Нэг. Асуудал 1

Хоёр. Асуудал 2

Ажлын хэсэг, хорооны гишүүд, сонсголд оролцож байгаа бусад нэр хүндтэй хүний нэрийг дурдан мэндчилж талархах нь эелдэг хэрэг, гэвч саналаа танилцуулах хайран цагаа бас хэмнэх шаардлагатайг санаарай.

ГОЛ ХЭСЭГ

Ийм байр суурь баримтлах болсон 1-р шалтгаанаа хэлэх

- Нэн тэргүүний чухал гэж үзсэн шалтгаанаа эхэлж дурдана.
- Энэ шалтгаанаа баталж нотлох тоо баримт, жишээ дурдаж танилцуулна.

Ийм байр суурь баримтлах болсон 2-р шалтгаанаа хэлэх

- Дараагийн хамгийн чухал, эсвэл нөлөө бүхий шалтгаанаа хэлнэ
- Энэ шалтгаанаа баталж нотлох тоо баримт, жишээ дурдаж танилцуулна.
 - Хамгийн чухал гэж үзсэн шалтгаан, тэдгээрийг дэмжсэн нотлох баримтуудаа үргэлжлүүлэн танилцуулна.
 - Хэлэх үг тань цагаасаа хэтэрч болохгүйг санаарай.

Хэлэх үгэндээ заавал багтаах зүйлээ сумаар тэмдэглэх, тодруулах, доогуур нь зурах зэргээр сандарч тэвдэлгүй олж харах, марталгүй санаад амар болгох арга хэрэглээрэй.

ДҮГНЭЛТ

Өөрийн байр суурийг дүгнэх хэл

- Иймд миний бие (ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЛБАН ЁСНЫ НЭР)-ийг ДЭМЖИЖ байгаагаа дахин илэрхийлэхийг зөвшөөрнө үү. (эсвэл “ЭСЭРГҮҮЦЭЖ байгаагаа” гэж хэлж болно)
- Дээр дурдсан асуудлуудыг төсөлд нэмж тусгана уу.

Үг сонсголыг зохион байгуулж үг хэлэх боломж олгосонд дахин талархал илэрхийл

- Өөрийн байр суурия шууд илэрхийлэх боломж гаргаж байгаад дахин талархал илэрхийлье.

Үргэлжлүүлэн туслахад бэлэн байгаагаа ажлын хэсэг, хороонд санал болго.

- “Хэрэв энэ асуудлаар нэмэлт мэдээлэл, туслалцаа шаардлагатай бол эргэлзэж тээнэгэлзэлгүй надтай холбоо бариарай.”

- Оролцогчид тухайн ажлын хэсэг, комисс, хороонд энэ асуудлаар үргэлжлүүлэн туслахад бэлэн байгаагаа ямагт илэрхийлэх хэрэгтэй. Хэрэв ажлын хэсэг, хорооны аль нэг гишүүн оролцогчийн үг, мэдүүлгийг үнэ цэнэтэй гэж үзвэл холбоо барьж дэлгэрэнгүй мэдээлэл авах болно.

4.3 Бичгээр саналаа өгөх

Нээлттэй сонсголд хувь хүний бичгээр өгөх санал нь дээд тал нь хоёр хуудас, албан байгууллагын хувьд дээд тал нь 6-7 хуудас байвал зохино. Хэрвээ түүнээс урт болсон бол хасч багасгаж, товч тодорхой, уншихад хялбар болгоход анхаарах ёстой. Хэт нуршуу, нэг санаагаа өөр өөр үгээр олон дахин давтсан зүйлийг уншихад цаг авахын зэрэгцээ ойлгоход ч амаргүй байдаг. Оролцогчид бичгээр саналаа гаргахдаа дараах зүйлийг санах ёстой.

Заасан хугацаанаас өмнө саналаа илгээх. Хэрэв оролцогч бичгээр өгөх саналаа нээлттэй сонсголын протоколд оруулахыг зорьж байгаа бол сонсголын зард заасан эцсийн



хугацаанаас өмнө амжуулж саналаа ирүүлэхэд анхаарах ёстой. Ямар хаягаар (шуудан, факс, цахим шуудан) саналаа ирүүлэхийг нээлттэй сонсголын зард тодорхой дурдсан байдаг. Хэрэв дурдаагүй орхисон байвал зохион байгуулагчидтай холбоо барьж асууж лавлаарай. Ихэнх нээлттэй сонсголд саналыг хурал болох өдрөөс дор хаяж 48 цагийн өмнө ирүүлсэн байх шаардлагыг тавьдаг. Ийм шаардлага тавихын учир нь зохион байгуулагчид оролцогчдоос бичгээр ирүүлсэн бүх саналыг ажлын хэсэг, байнгын хорооны гишүүдэд тарааж сонсголоос өмнө уншиж танилцах боломж олгодогтой холбоотой.

Жишээ татаж сонирхолтой болгох.: Санаалыг амаар, бичгээр аль хэлбэрээр гаргаж байгаагаас үл шалтгаалан оролцогчид тухайн хэлэлцүүлж буй төсөлтэй холбогдох жишээ баримт дурдах нь хэлэх санаагаа тодруулж, ач холбогдлыг нь таниулахад чухал нөлөөтэй. Гэхдээ энд тэндээс статистик тоо хуулж тавихаас илүүтэй бодит амьдралаас авсан баримт жишээ дурдах нь санаалыг унших хүмүүст сонирхолтой бөгөөд таны хэлэх саналд хүч өгч, уншигчдад хүрч нөлөөлөх нь илүүтэй байх магадлалтай. Тухайлбал,



Нийгмийн хalamжийн тухай хуулийн 18-ын 1.4-д хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, бие дааж амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэтгэвэр авах эрхтэй байхаар зааж, өмнө 50 хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд олгодог байсан тэтгэвэр, тэтгэмжийг зогсоо тухай шийдвэрийн төслийг эсэргүүцсэн санал гаргаж буй бол:

Нийгмийн хalamжийн тухай хуульд шинээр тусгагдсан энэ заалт батлагдвал хөдөлмөрийн чадвараа 50 хувиар алдсан, ажил хөдөлмөр эрхлэн гэр бүлээ тэжээж тэтгэх боломжгүй олон хүн хalamж хүртэж чадахгүйд хурч байна. Нэг жишээ дурдья. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Булаг багт амьдардаг Жавхлан овогтой Баярсайхан 32 настай. Эхнэр Жаргал 30 настай, ажил эрхэлдэггүй. Эднийх 0-12 наасны 3 хүүхэдтэй. Баярсайхан 2006 онд ослос болж өрөөсөн нүдгүй болсон. Эрүүл мэндийн сайдын 1997 оны A/250 дугаар тушаалын “Ердийн өвчний гэмтлийн жагсаалт”-ын 6 дугаар бүлгийн 5 дахь заалтаар өрөөсөн нүд сохор болсон хумуусийг 50 хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан гэж тооцдог. Баярсайхан ажил хийж амьдрал ахуйгаа өөд татах хүсэлтэй ч өрөөсөн нүдгүй шалтгаанаар ажилд авдаггүй. Энэ өрхийн гол орлого нь Баярсайханы авдаг тэтгэвэр, 3 хүүхдийнх нь тэтгэмж. Өрхийн нийт орлого нь сард 84000 төгрөг бөгөөд энэ орлого нь хоол унд зэрэг наад захын хэрэгцээгээ хангахад ч хүрдэггүй. Нийгмийн хalamжийн тухай хуульд шинээр тусч буй дээрх заалт батлагдвал Баярсайхан хalamжийн тэтгэвэрээ авах боломжгүй болж энэ өрхийн амьдрал улам дорийтох нь тодорхой байна.

Түүнчлэн өмнө дурдсанчлан, зөвхөн бичгээр санал өгч байгаа үед сонсголд биечлэн оролцож үг хэлж байгаа хүмүүсээс ялгаатай нь ажлын хэсэг, байнгын хорооны асуултад хариулж байр суурь, үзэл бодлоо тайлбарлах боломжгүй байдаг. Иймд саналаа боловсруулах явцад тэдний зүгээс гарч болзошгүй гэж үзсэн асуултуудад аль болох хариулт өгч бичихийг хичээх нь зүйтэй (**6.5 дугаар хэсэгт удирдамж болгон оруулсан асуултуудыг үзнэ үү**).

Энгийн ойлгомжтой үг хэллэг ашиглах: Бичгээр санал гаргахдаа мэргэжлийн болон этгээд сонин үг хэллэг, жаргон хэрэглэхээс аль болох зайлсхийж, товч тодорхой байж нуршигүй байхыг хичээх нь зүйтэй. Цаасан дээр буулгасан зүйл ойлгоход хялбар, цэгтэй бичигдсэн байх тусам уншигч төдий чинээ их мэдээлэл авч, тэр хэмжээгээр таны санал ажлын хэсэг, байнгын хорооны гишүүдэд нөлөөлнө гэдгийг ойлгоорой. Түүнчлэн бичгээр илгээх саналдаа хурц шүүмжлэл дэвшүүлж болох ч бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй байх ёстой.



Хувилбар 1. Хэт нуршсан ойлгомж муутай өгүүлбэр

Нийгмийн халамжийн хуулийн 9-р зүйлд “Иргэдлийн амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл байгуулахаар заасан” хуулийн заалт нь орон нутагт иргэдийн оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог буй болгох, оршин суугч иргэдийн хэн нь ядуу, амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой байгааг тодорхойлох, мөн хэнд халамж тусlamж өгч болох талаар айл өрх бүрээр орж судалж, ялгаж, шийдэж байх хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий сум, хороодын засаг дарга нар энэ ажлыг хийх байтугай энэ хуулиа ч мэддэг нэг ч засаг дарга алга байна.

Хувилбар 2. Өгүүлбэрийг хоёр хэсэгт хувааж, уншигч ойлгоход хялбар болгосон байдал

Нийгмийн халамжийн тухай хуулийн 9-р зүйлд “Иргэдлийн амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл байгуулахаар” заасан нь орон нутаг дахь иргэдийн оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх, улмаар хөндлөнгийн хяналтын тогтолцоог буй болгох төдийгүй оршин суугчдын хэн нь ядуу, амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой байгааг тодорхойлох, хэнд халамж тусlamж өгч болох талаар айл өрх бүрээр орж судалж, ялгаатай хандан шийдвэрлэж байх зорилготой юм. Гэтэл энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий сум, хороодын засаг дарга нар уг үүргээ биелүүлэх нь байтугай хуулийн заалтыг мэддэг эсэх нь ч харагдахгүй байна.

Бичсэнээ хянаж, алдаагаа засах: Саналаа боловсруулж бэлтгэж дуусаад байнгын хороо, ажлын хэсэгт илгээхийн өмнө үг үсэг, найруулгын алдааг сайтар шалгаж, анхааралтай хянах нь чухал. Эхний төслөө бичиж дууссаны дараа оролцогч өөрөө уншиж засахаас гадна найз нөхөд, хамт ажилладаг хүмүүсээр хянуулаад үзэхэд илүүдэхгүй. Түүнчлэн өөрийн бичсэнийг олон дахин уншицаар ядарсан үед алдаагаа олж харахгүй, анзаарахгүй орхих явдал гардаг. Иймд бичсэнээ хянаж дууссаны дараа шаардлагатай засваруудыг хийж, нэг өдөр уншилгүй хойш тавиад эргэн үзэхэд анзааралгүй орхисон алдааг олж харахад тус болох нь бий.

Оролцогчид саналаа бичгийн машинаар эсвэл компьютерт бичсэн хувийг илгээх нь унших хүмүүст гаргацтай байдаг. Бичгийн машин, компьютергүй бол гараар бичсэн хувия ч явуулж болно. Гэвч гараар бичсэн зүйлийг уншихад заримдаа гаргац муутай байж магадгүйгээс гадна оролцогч өөртөө хувийг авч үлдэхийн тулд дахин хуулах хэрэг гарч болохыг анхаарарай.

Саналд орсон мэдээллийн үнэн зөв байдал онцгой чухал. Оролцогч ямар ч тохиолдолд баталгаагүй жишээ, баримт дурдах ёсгүй.



Бичгээр өгөх саналын загвар (жишээ)

Оролцогч бичгээр өгөх саналаа ажлын хэсэг, иргэний танхим, байнгын хороонд хандсан албан ёсны захидалтын хэлбэрт оруулах ёстой. Иймээс оролцогчид саналаа албан ёсны захидал бичиж байгаа мэт эхэлж, дуусгах хэрэгтэй.

УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ НЭР, АЖЛЫН ХЭСЭГ, ЭСВЭЛ ИРГЭНИЙ ТАНХИМД ГЭЖ ХАЯГЛАХ

Таны нэр

Таны төлөөлж байгаа байгууллагын
нэр, харилцах хаяг

“Хуулийн төслийн нэр” - ийг хэлэлцэх сонгсолд (огноо)

Юуны өмнө энэхүү чухал хуулийн төслийн талаар санал гаргах боломж олгож буйд талархаж буйгаа уламжилж. Миний нэрийг Дорлигийн Дуламжав гэдэг. Би АБВ төрийн бус байгууллагад ажилладаг. Манай байгууллага нь (хэлэлцэх асуудалтай холбоотой ямар үйл ажиллагаа явуулдаг, туршлагатай байгууллага болохыг тайлбарлана)... үйл ажиллагаа явуулдаг

“Хуулийн төслийн нэр”-ийн “зүйл заалтын дугаар”-д (энд тухайн заалтын агуулгыг дурдаж болно) гэж заасныг эсэргүүцэж (эсвэл “дэмжих”) энэхүү саналыг гаргаж байна.

Нэг. Толгой хэсэг

Оролцогчид дараах мэдээллийг албан бичгийн дээд хэсэгт уншигчийн нүдэнд хялбар харагдахаар бичнэ:
 1. Ажлын хэсэг, Байнгын хороо, хурал даргалагчийн нэр, эсвэл Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд гэж өрөнхий хаяглаж болно.

- Хуулийн төслийн нэр
- Хэлэлцүүлэг явагдах огноо, цаг, газар
- Оролцогчийн бүтэн нэр, холбоо барих хаяг (Ажлын хэсэг, комисс, хорооны гишүүд оролцогчоос нэмэлт мэдээлэл авах шаардлага гарахад холбоо барих хаяг, утас байх ёстой)

Хоёр. Оршил хэсэг

1. Оролцогчийн танилцуулга: Нэр ус, хэнийг төлөөлж байгаа, тухайн хуулийн төсөл эсвэл асуудалтай холбоотой туршлага байгаа бол дурдана. Санал ирүүлэх боломж олгосонд байнгын хороонд талархах хэрэгтэй. Хэтэрхий нуршуу байх хэрэггүй.

- Тухайн асуудал буюу хуулийн төслийн талаарх оролцогчдын байр суурь: Ажлын хэсэг, хорооны гишүүд оролцогчийн байр суурийг мэдэх гэж бичсэн саналыг бүхэлд нь самнаж уншихад хүндрэлтэй байдаг учир хамгийн түрүүнд тодорхой дурдах ёстой

ГОЛ ХЭСЭГ

- Ийм байр суурь баримтлах болсон 1-р шалтгаанаа бичих

- Хамгийн чухал ач холбогдолтой шалтгаанаасаа эхэлнэ.
- Энэ шалтгаантай холбоотой, бататгах тоо баримт, нотолгоо, мэдэгдэл, хувийн туршлагыг танилцуулна.

- Ийм байр суурь баримтлах 2-р шалтгаанаа бичих

- Дараагийн хамгийн чухал буюу нөлөө бүхий шалтгаанаа бичнэ.
- Энэ шалтгаанаа дэмжсэн ямар нэг тоо баримт, нотолгоо, мэдэгдэл, хувийн туршлагыг танилцуулна.

*** Хамгийн их ач холбогдолтойгоос ач холбогдол багатай хүртэл шалтгаануудаа жагсаан бич, ингэхдээ санал 1-2 хуудаст багтах ёстойг давхар санаарай. ***

Энд өөрийн саналын үндэслэлийг тайлбарлаж, жишээгээ дурдана.

- Эсэргүүцэж байгаа бол ягаад, ямар сөрөг үр дагавар байгааг тодорхой хэлэх, жишээ татах
- Дэмжиж байгаа бол ямар сайн үр дүн гарч нөлөөлөхийг тайлбарлаж, боломжтой бол жишээ, тоо баримт, тооцоогоор баяжуулах

ДҮГНЭЛТ

Төслийг эсэргүүцэж байгаа бол:

- Эдгээр баримт, шалтгаануудад үндэслэн (ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЛБАН ЁСНЫ НЭР)-ийн төсөлд дараахь өөрчлөлтүүдийг оруулах саналтай байна. Үүнд:
 - 1.
 - 2.
- Дээр дурдсан үндэслэл, шалтгааныг харгалзан зохих арга хэмжээ авна гэж найдаж байна.

Та саналаа дараахь байдлаар дүгнэж төгсгөх болно.

- Дэмжиж/эсэргүүцэж байгаагаа дахин бататган илэрхийлэх
- Авч болох арга хэмжээний талаар санал, зөвлөмжээ бич

Төслийг дэмжих байгаа бол:

- Дээрх үндэслэл шалтгаанаар (ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЛБАН ЁСНЫ НЭР)-ийн төслийг дэмжих буйгаа дахин илэрхийлье.

ТӨГСГӨЛ

Ажлын алба, байнгын хороонд шаардлагатай гэж үзвэл үргэлжлүүлэн туслахад бэлэн байгаагаа илэрхийл.
“Хэрэв энэ асуудлаар нэмэлт мэдээлэл шаардлагатай бол надтай/ бидэнтэй доорхи хаягаар холбоо бариарай.”
Хүндэтгэсэн,

Дорлигийн Дуламжав
Төслийн зохицуулагч
АБВ Төрийн бус байгууллага
Сүхбаатар дүүрэг
Сөүлийн гудамж 5-1
Улаанбаатар хот
Утас: 9901.....
Эшуудан:

Үргэлжлүүлэн туслахад бэлэн байгаагаа ажлын хэсэг, байнгын хорооныхонд ямагт санал болго.

1. Гарын үсэг зураад, ард нь нэрээ дахин бич
2. Өөрийн төлөөлж байгаа байгууллагын нэрийг дахин дурд
3. Холбоо барих хаягийн мэдээллээ бүрэн оруул
 - Хаяг
 - Утасны дугаар
 - И-мэйл хаяг (хэрэв байгаа бол)

*** Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэгдэж буй Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг дэмжсэн санал***



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-1, 40-р байрны 2, 6 тоот
Утас: 318087, 318086
И-мэйл: mongolcav@magicnet.mn

Монгол Улсын Их Хурлын
Хууль зүйн байнгын хороонд

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг хэлэлцэх сонсголд

2009 оны 10 сарын 22

Энэхүү чухал хуулийн төслийн талаар санал гаргах боломж олгон, нээлттэй сонсголыг зохион байгуулсанд талархаж байгаагаа илэрхийлье. Намайг Энхжаргал гэдэг. Би “Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв” төрийн бус байгууллагад ажилладаг. Манай төв нь жендерт суурилсан хүчирхийллийг бууруулахын төлөө сүүлийн 15 жилийн турш тасралтгүй ажиллаж ирсэн.

“Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн төслийг дэмжих энэхүү саналыг гаргаж байгааг хүлээн авна уу !

Жендер нь эрэгтэй эмэгтэй хүйсийн аль алинд нь хамаатай асуудал. Тэгш байдал нь тэгш боломжоос илүү өргөн хүрээтэй ойлголт. Энэ нь бүх хүмүүс хүйс, үндэс угсаа, нийгмийн давхарга, шашин шүтлэг, итгэл үнэмшил, бэлгийн чиг хандлагын хувьд өөр өөр байхаас үл шалтгаалан ижил хэмжээнд үнэлэгдэж, адил боломжоор хангагдана гэсэн үг.

Манай улсад үйлчилж байгаа хууль, бодлогод эмэгтэй эрэгтэй хүмүүсийн эрх, үүргийн хувьд ялгаатай зүйл байдаггүй. Гэвч бодит амьдрал дээр жендерийн тэгш бус байдал газар авч, өмнөх жилүүдэд олсон зарим ололтоос ухрах хандлага үүсээд байна. Энэ талаарх зарим жишээнүүдэд Та бүхний анхаарлыг хандуулахыг хүсч байна:

1. Эр хүн болон эмэгтэй хүний тухай хэвшмэл ойлголт нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль алинд сайн зүйл авчрахгүй байна. Тухайлбал, эрэгтэй хүний үүрэг хариуцлагын талаар тогтсон жендерийн хэвшмэл үзэл тэдэнд сөрөг нөлөөг авчирч, өөрөөрөө байх боломжийг нь хаах болсон. Ажлын байр хомс, орлого олох бололцоо хязгаарлагдмал байгаагаас гэр бүл, нийгэмд эзлэх байр суурь нь буурахад хүрсэн өнөөгийн нөхцөл байдал нь “жинхэнэ эр хүн”-ий талаарх үзэл хандлагатай нь зөрчилдсөнөөс

олон эрчүүд бужимдалд автаж, архинд донтох, зөрчилдөөнтэй асуудлаа хүч хэрэглэх аргаар шийдвэрлэх зэргээр гэмт үйлдэлд холбогдох нь нэмэгдсээр байна. Эмэгтэйчүүдийг ажилд авахдаа нас, хүйс, царай зүсээр нь ялгаварлан гадуурхдагаас ажил олддоггүй, хүүхдээ өсгөх, гэр бүлийн гишүүдээ асран халамжлахад зарцуулсан хөдөлмөр нь үнэлэгдэггүйгээс ажлын байрны цомхотголд өртөх, ажлаасаа халагдах эрсдэл өндөр зэргээс шалтгаалан нийгмийн халамж, хамгааллын баталгаа багатай албан бус секторт тэд олноор ажиллахад хүрсэн. Ижил ажил эрхэлдэг эрэгтэй эмэгтэй хүмүүсийн цалингийн ялгаа зарим салбарт эрчимтэйгээр нэмэгдэж байгаа зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан эмэгтэйчүүдийн дунд ядуурал ихэссэн. Иймээс эмэгтэй, эрэгтэй хүн юуг хийвэл зохих, юуг хийж болохгүй талаарх нийгмээс тулган хүлээлгэсэн хэвшмэл зарчимд захирагдахгүйгээр хүн бүр өөрөөрөө байх боломжийг олгоход тус хуулийн төсөлд тусгагдсан жендерийн ялгаварлан гадуурхалтыг хориглох арга хэмжээ чухал баталгаа болно гэж би үзэж байна.

- 2.Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхдээ эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг хайхардаггүй, холбогдох бодлого, үйл ажиллагааг төлөвлөхдөө анхаарч тооцдоггүй. Тухайлбал, боловсролын бүхий л салбарт суралцагчдын дунд охид давамгайлж, хөвгүүдийн сургуульд хамрагдалт буурсан. Энэ нь амьжиргааны боломж муутайгаас хөвгүүдийг өрхийн орлогoo нэмэгдүүлэх ажилд оролцуулдаг хэрэгцээнээс үүдэлтэй байсан нь дүн шинжилгээгээр тогтоогдсон. Түүнчлэн эрэгтэйчүүдийн дундаж наслалт богино, цус харвалт, зүрхний шигдээс өвчний түвшин өндөр, гадны хүчин зүйлийн улмаас амь насаа алдах тохиолдол их байна. Гэвч улсын хэмжээнд тэдэнд зориулсан, хямралыг даван туулахад туслах үйлчилгээ байхгүй, эрэгтэйчүүдийн эмч, эмнэлэг ганц хоёрхонаос хэтрээгүй баримт нь эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээг тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлдэггүйг илтгэж байна. Энэ нь аливаа мэдээллийг хүйсээр ангилсан байдлаар гаргаж, тэгш байдал алдагдсан тохиолдлыг цаг алдахгүй илрүүлэх, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харилцааны асуудлаар нухацтай үнэлгээ хийх тогтолцоо бий болоогүйг харуулж байна. Энэ хууль батлагдвал хүйсээр ялгасан мэдээллийг цуглуулан, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль алины онцлог хэрэгцээг харгалзсан үйл ажиллагаа, үйлчилгээ хөгжих суурь нөхцөл бүрдэнэ. Жендерийн баримжаатай бодлого төлөвлөгдөн хэрэгжсэнээр эрэгтэй эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд нөөц боломж тэгш хуваарилагдах болно.
- 3.Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөлд нийгмийн бүх хүрээнд тэгш хуваарилалтыг дэмжих, бүхий л албан тушаалд томилогдон

ажиллах боломжоор тэгш хангагдах баталгаа багтсан байгааг дэмжиж байна. Ажилд авахдаа баримтлах хамгийн гол зарчмуудын нэг нь ажилтнуудын хүйсийн харьцааг хүн амын бүтцийн харьцаатай уялдуулах шаардлага ба аливаа бүлэг доторхи эмэгтэй эрэгтэй хүмүүсийн харьцаа наад зах нь 40x60 буюу түүнээс дээш байх явдал гэж олон улсын түвшинд үздэг. Хэрвээ энэхүү харьцаанд аль нэг хүйсийн хүмүүсийн эзлэх хувь 60-аас дээш байвал энэ бүлэгт эрэгтэйчүүд эсвэл эмэгтэйчүүд давамгайлсан хандлага үүснэ. Иймээс бүх салбарт ажиллагсад хүйсийн хувьд тэгш харьцаатай байх нь охид, хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн аль алиных нь хэрэгцээг ижил түвшинд хангах боломжийг бүрдүүлнэ.

Энэ хууль батлагдсанаар эмэгтэй эрэгтэй хүмүүс ижил эрх, боломж эдэлж, үүрэг хүлээж, аль алиных нь хэрэгцээ, санал бодол, туршлага адил түвшинд үнэлэгдэх болно. Нийгэм, эдийн засаг, улс төр, гэр бүл зэрэг нийгмийн амьдралын бүх хүрээний бодлогыг төлөвлөхөөс эхлээд боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх зэрэг үе шатуудад тухайн үйл ажиллагаа эрэгтэй эмэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлөх талаас нь дүгнэлт хийгдэх ажил бүхий л байгууллагуудын өдөр тутмын үйл явц болно гэсэн үг.

Иймээс Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг дэмжихийг Та бүхнээс хүсч байгаагаа дахин илэрхийльв.

Хэрэв энэ асуудлаар нэмэлт мэдээлэл шаардлагатай бол бидэнтэй доорх хаягаар холбоо барина уу!

Хүндэтгэсэн,
Д. Энхкаргал, ХЭҮТ-ийн Гүйцэтгэх захирал

Е-мэйл: mongolcav@mongolnet.mn

Вэб: www.safefuture.mn

Утас: 70119949

5. НЭЭЛТТЭЙ СОНСГОЛЫН ӨМНӨ

Нээлттэй сонсгол болохын өмнө оролцогчид бэлтгэлээ аль болох сайн хангах хэрэгтэй талаар бид олонтаа дурдсан. Бэлтгэлээ бүрэн хангасан, сонсголд оролцоход бэлэн эсэхээ шалгахад дараахь хуудсыг ашиглахыг зөвлөж байна.

5.1 Шалгах хуудас



- Нээлттэй сонсголын зарыг шалгаж шаардлагатай мэдээллийг авах
- Бичгээр өгөх саналаа эцсийн хугацаанаас нь өмнө (20.. оны 9 дүгээр сарын 25-наас өмнө) илгээх
- Нээлттэй сонсгол болох газрыг олж мэдэх
- Асууж лавлах зүйлээ сонсголоос өмнө амжуулж асууж мэдэх
- Ажлын хэсэг, комисс, байнгын хороонд өгөх саналын хувийг хянаж завсарлаж бэлтгэх
- Саналаа хувилж олшруулж бэлтгэх
- Сонсголд саналаа хэлж танилцуулах давтлага хийх
- Нээлттэй сонсголд оролцооор бүртгүүлэх (20.. оны 9 дүгээр сарын 28-ны өдөр)
- Нээлттэй сонсголд оролцох өдрийн ажлын хуваарияа тодорхой болгох

Нээлттэй сонсголын зарыг шалгаж чухал мэдээллүүдээ олж авах.
Нээлттэй сонсгол болохын өмнөх өдрүүдэд оролцогчид зарыг анхаарлтай уншиж, дараахь зүйлийг мэдсэн байх шаардлагатай.

Нээлттэй сонсгол хэзээ болох вэ (өдөр, цаг)?

Нээлттэй сонсгол хаана болох вэ?

Үг сонсголыг аль байгууллага, ажлын хэсэг, байнгын хороо зохион байгуулах вэ?

Саналыг ямар хэлбэрээр хүлээн авахаар зард өгүүлсэн байна вэ?

Бичгээр санал хүлээж авах эцсийн хугацаа нь хэзээ вэ?

Оролцогчид хэдий хэр хугацаанд саналаа багтааж танилцуулахыг шаардаж байна вэ?

Ямар нэг асуудал гарахад зохион байгуулагчтай ямар утсаар холбоо барьж болох вэ?

Асууж лавлах зүйлээ сонсголоос өмнө асууж мэдэх: Нээлттэй сонсгол болох өдөр хэлэлцэгдэх төсөлтэй холбоотой асуулт тавих, эсвэл нэмэлт мэдээлэл олж авах гэвэл хэтэрхий оройтсон хэрэг болно. Иймд асууж лавлах зүйлээ сонсгол болохоос нэлээд хэд хоногийн өмнө асууж тодруулах хэрэгтэй.

Нээлттэй сонсгол болох газрыг олж мэдэх, хоцрохгүй очих бэлтгэлээ хангах: Сонсголд оролцогчдын байнга гаргадаг нэг алдаа нь нээлттэй сонсгол хаана болохыг гэнэт тэр өглөө нь хайж, сураглаж эхэлдэг явдал юм. Сонсгол болох өдрөөс хэд хоногийн өмнө хаана болох гэж байгааг олж мэдэн, тэр газар яж очихоо төлөвлөх нь зүйтэй. Тухайлбал, автомашин жолоодж очих гэж байгаа бол зогсоол олж машинаа тавихад хэр хугацаа шаардагдахыг ч марталгүй тооцож хоцрохгүй очихыг бодоорой. Хоцорч ирэх нь хурлын явцад саад болоод зогсохгүй, оролцогч талуудад хүндэтгэлгүй хандсан бүдүүлэг хэрэг болно.

Түүнчлэн нээлттэй сонсгол болох өдрөөс өмнө зохион байгуулагчидтай холбоо барин сонсгол болох газарт нэвтрэхэд ямар бичиг баримт шаардлагатай тухай лавлахад илүүдэхгүй. Тухайлбал, Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулж буй сонсголд оролцох бол иргэний үнэмлэх, ажлын газрын үнэмлэх /төрийн байгууллага/, гадаад паспорт, жолооны үнэмлэх, эсвэл өндөр настны үнэмлэхээ заавал авч очих шаардлагатай. Учир нь Төрийн ордны хамгаалалт үйлчилгээний журмын дагуу дээрх бичиг баримтын аль нэгийг үзүүлээгүй иргэдийг ордонд нэвтрүүлдэггүй.


Түүнчлэн нэн хоцрогдсон хэмээн иргэдийн шүүмжлэлийг хүлээсээр ирсэн ч өдий болтол Төрийн ордонд нэвтрэхэд үйлчилсээр байгаа нэг дүрэм нь дээр дурдсан журмын 3.1.8-д заасан “Биеийн тамирын, чөлөөт амралтын, ажлын болон этгээд загварын, нуруу, хэнхдэг ил гарсан, гэрэлтдэг нимгэн хувцас, өвдөгнөөс дээш богино банзал, бохирдсон хувцастай” иргэдийг

Төрийн ордоонд нэвтрүүлэхийг хориглодог явдал юм. Сонсголд оролцохоор очиждоо үүнийг бас санаарай.

Санал, хэлэх үгээ хувилж олшруулж бэлтгэх: Зарим үед хуралдаан даргалагч нээлттэй сонсголд үг хэлэх хүмүүст саналынхаа олшруулсан хувийг илтгэж эхлэхийн өмнөхөн ажлын хэсэг, байнгын хорооны гишүүдэд тарааж өгөхийг зөвшөөрдөг. Ажлын хэсэг, байнгын хорооны гишүүд оролцогчийн мэдүүлгийг өмнөө тавьж сонсох нь илүү нарийвчлан уншиж, шаардлагатай бол дээр нь тэмдэглэл хийх боломж олгодог. Иймээс хурал даргалагч оролцогчид хэлэх үг, саналынхаа хувийг тараахыг зөвшөөрч магадгүй гэж санан бэлтгэлтэй байх үүднээс 15 хүртэл тоогоор хувилж авчирсан байх хэрэгтэй.

Давтлага хийж, анхаарлаа төвлөрүүлэх: Оролцогчид олны өмнө ярихдаа сандарч тэвдэх нь зүйн хэрэг. Ихэнхи хүн, туршлагатай илтгэгчид хүртэл олон хүний өмнө үг хэлэхээс эмээдэг. Гэхдээ өөрийгөө сайн тайвшруулж бэлтгээгүй хүн шийдвэр гаргагчдыг уриалан дуудаж, ятгаж, сэтгэлийг нь хөдөлгөх чадвараа алддаг. Дадлага хийх нь хурлын индэр дээрээс үгээ тод бөгөөд өөртөө итгэлтэй хэлэхэд туслана. Оролцогч хэлэх үгээ хэдий чинээ сайн бэлдэж, давтах тусам төдий чинээ дадал эзэмшиж нээлттэй сонсгол дээр саналаа хэлэх ээлж ирэхэд өөртөө итгэлтэй, тайван байх болно. Хэлэх саналынхаа эцсийн хувилбарыг бэлтгэж дууссан бол хэд хэдэн удаа чангаар уншиж давтлага хийх хэрэгтэй. Ийнхүү дасгал хийж байхдаа түгдэрч сандралгүй ярьж, үгээ тод, жигд хэлэхэд анхаарах ёстой. Олны өмнө ярих туршлага мутай хүн байсан ч гэсэн дадлага сайн хийсэн бол туршлагатай илтгэгчээс дутахааргуй байж чаддаг.

Сонсголд оролцохоор бүртгүүлэх: Хэлэлцэх асуудлаас хамаараад сонсголд оролцогчдын тоо хэдэн арваас хэдэн зууд хүрэх тохиолдол гардаг тухай өмнө нэгэнтээ дурдсан. Асуудал нь маргаантай байх тусмаа эсрэг тэсрэг байр сууриа хамгаалахын тулд сонирхогч



талуудаас олон хүн ирж оролцдог. Үүнтэй холбоотой зохион байгуулагчид нээлттэй сонсголд оролцогчдыг бүртгэн авч нэрийн жагсаалт гаргадаг. Ингэж жагсаалт гаргаснаар оролцогчдын үг хэлэх ээлж дарааллыг тогтоох, эсвэл сонсголыг олон хүн

багтаж өөр байранд зохион байгуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах боломж бүрдэнэ. Түүнчлэн Монгол Улсын төрийн ордон зэрэг төрийн тусгай хамгаалалтад байдаг байранд сонсгол болох бол урьдчилж заавал бүртгүүлсэн байх ёстой. Энэ нь ажиглагчаар оролцогчдод ч хамаатай.

Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимиын нээлттэй сонсголд оролцогчдын бүртгэл нь сонсгол болохоос ажлын гурван хоногийн өмнө 9-18 цаг хүртэл явагдахаар журамд тусгагдсан байна. Оролцогч энэ өдөрт амжиж утас, факсаар юм уу, эсвэл зарлалд дурдсан цахим шуудангийн хаягаар өөрийн нэрийг бүртгүүлнэ. Бүртгэлийн тухай сонсголын зард дурдсан байх тул хэрхэн яж бүртгүүлэх тухай мэдээллийг юуны түрүүнд зараас хайж үзэх хэрэгтэй. Зард энэ талаар мэдээллийг дурдаагүй орхисон байвал зохион байгуулагчидтай нэн даруй холбогdon асууж лавлаарай.

Нээлттэй сонсголд оролцох өдрийн хуваарияа тодорхой болго: Гарын авлагын эхэнд тэмдэглэж байсанчлан нээлттэй сонсгол нь хүссэн хүн бүр



оролцох боломжтой нээлттэй үйл явц. Гэвч сонсголын эхлэх цагаас хоцорч ирэх, уг хэлэх ээлж нь болоогүй байхад бусдын өмнүүр дайрч индэрт гарах гэж зүтгэх, хурлын дундуур гарах, эсвэл оролцооор бүртгүүлсэн ч ирэхгүй байх зэрэг үйлдэл гаргах нь хурлын явцыг үймүүлж, оролцогчдод саад болдог. Иймээс нээлттэй сонсголд оролцооор бүртгүүлсэн бол тухайн өдрийн цагийн хуваарияа эртнээс зохицуулан зөв төлөвлөж тодорхой болгох хэрэгтэй. Тухайлбал, бага насны хүүхдээ харж асрах хүн хайж олохоос эхлээд ажлаасаа нэг

өдрийн чөлөө авах шаардлага ч гарч болно. Орон байраа нүүлгэх гэж байгаа бол түр хойш нь тавьж сонсголыг боломжоороо эхнээс нь дуустал байлцахаар төлөвлөнө гэсэн үг. Хэрэв сонсголыг эхнээс нь дуустал байлцах боломжгүй бол эртхэн бүртгүүлж, нэрээ үг хэлэх хүмүүсийн жагсаалтын эхэнд байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Хэрэв оролцогч сонсгол болох өдрийн хуваария тодорхой болгож зохицуулж чадахгүй бол оролцох эсэхээ дахин бодолцож шийдвэр гаргавал нэн даруй зохион байгуулагчдад мэдэгдээрэй.

6. НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ ДЭЭР

Нээлттэй сонсголын өдөр ирлээ. Сонсголд оролцохоор шийдсэн бол гарын авлагын тавдугаар хэсэгт танилцуулсан шалгах хуудасны дагуу оролцох бэлтгэлээ хангасан гэдэгт итгэлтэй байна. Гэхдээ найдвартай байхын тулд оролцогчид шалгах хуудсаа дахин нэг удаа уншиж үзээд нээлттэй сонсголд хэрэгтэй бүх мэдээлэл, материалаа авсан эсэхээ шалгаад үзээрэй.

6.1 Үг хэлэх дарааллаа бүртгүүлэх

Нээлттэй сонсгол болох газар ирээд хамгийн түрүүнд зохион байгуулагчдын бэлтгэн тавьсан бүртгэлийн хуудаст нэрээ бичүүлж ирснээ мэдэгдэх явдал юм. Оролцогчид бүртгүүлэхдээ өөрсдийн нэр, санал гаргах эсэх, байгууллага төлөөлж оролцож байгаа эсэх зэрэг шаардагдах бүх мэдээллийг бүртгэлийн хуудас дээр бүрэн бүтэн бөглөж мэдээлэх ёстой. Ихэнх сонсгол дээр талуудын үг хэлэх, санал гаргах дарааллыг дөрвөн бүлэгт хувааж, аль бүлэгт орсон эсэхээс хамаарч тогтоодог. Тухайн бүлэг дотроо үг хэлэх дарааллыг түрүүлж ирсэн нь эхлэх байдлаар тогтооно. Иймээс оролцогч аль болох эрт ирж бүртгүүлэх тусам төдийчинээ хурдан индэрт дуудагдах болно.

1 дүгээр бүлэг

хөндлөнгийн шинжээч, эксперт, төрийн болон олон улсын байгууллагын холбогдох албаны хүмүүс, урилгаар оролцож буй хүмүүс үг хэлэх

2 дугаар бүлэг

төслийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг дэмжсэн байр суурьтай хүмүүс

3 дугаар бүлэг

төслийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг эсэргүүцсэн байр суурьтай хүмүүс

4 дүгээр бүлэг

тайлбар, саналтай хүмүүс



Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:

Найм. Хэлэлцүүлгийн дэг

- 8.5. Оролцогчдын үг хэлэх дарааллыг хэлэлцүүлэг даргалагч тогтооно. Ингэхдээ энэ журмын 7.4 дэх заалтын дагуу бүртгүүлсэн нэрсийн дарааллыг үндэслэн дараахь дэс дарааллыг давхар баримтлан индэрт урина.
- 8.5.1. хөндрүүнгийн шинжээч, эксперт, төрийн болон олон улсын байгууллагын холбогдох албаны хүмүүс үг хэлэх,
 - 8.5.2. төслийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг дэмжсэн байр суурьтай хүмүүс болон тэдгээрийн гэрч үг хэлэх,
 - 8.5.3. төслийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг эсэргүүцсэн байр суурьтай хүмүүс болон тэдгээрийн гэрч үг хэлэх,
 - 8.5.4. тайлбар, саналтай хүмүүс үг хэлэх.

Хэрэв төслийг дэмжсэн, эсэргүүцсэн, төсөлд санал тайлбар хийхийг хүссэн хүний тоо тус бүр 3-аас илүү бүртгэгдсэн бол тэдгээр байр суурьтай хүмүүс эзлжлэн үг хэлнэ.

6.2 Хуралдаан даргалагчийн зааврыг сонсох

Нээлттэй сонсголыг ажлын хэсэг, байнгын хорооны дарга буюу хороо, ажлын хэсгээс томилсон хүн удирдан явуулна. Сонсгол эхлэхэд дарга нээлттэй хэлэлцүүлгийг нээж товч үг хэлэн сонсголын зорилго, дэг журмыг тайлбарлана. Тухайлбал, оролцогчдын үг хэлэх дараалал, хугацаа, оролцогч үг хугацааг хэтрүүлж яривал хэрхэх тухай индэрт дуудагдсаны дараа саналаа хэлэхэд анхаарах журам, хороо, ажлын хэсгээс асуулт тавих болон оролцогч түүнд хэрхэн хариулах процедур, хэдийд завсарлага авахыг болон хамгийн чухал нь оролцогчид нээлттэй хэлэлцүүлгийн үеэр баримтлах ёс зүйн дүрмийг танилцуулдаг.

6.3 Нээлттэй сонсголын үед баримтлах ёсзүйн дүрмүүд

Сонсголын явцад ямар ч тохиолдолд мөрдөх учиртай ёсзүйн дүрмүүд байдаг. Оролцогчид эдгээр дүрмийг мөрдөх нь сонсгол амжилттай бөгөөд саадгүй явагдаж, улмаар оролцогч бүрт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж бодлогын үйл явцад оролцох эрхээ адил тэгш эдлэх боломж бүрдэнэ. Зарим үед сонсголыг замбараатай, цэгцтэй явуулах үүднээс хуралдаан даргалагч нар янз бүрийн дүрэм гаргах явдал тохиолддог. Гэвч ихэнхи нээлттэй сонсголд дор дурдсан нийтлэг ёс дүрмийг баримталдаг.

Бусад хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд хүндэтгэлтэй хандах. Нээлттэй сонсгол нь хүссэн хүн бүр нас хүйс, гарал үүсэл, боловсролын түвшин, итгэл үнэмшлээсээ үл хамааран үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нээлттэй чуулган юм. Иймээс хэн нэг оролцогч үгээ хэлж, хууль, шийдвэрийн төслийн талаарх санаалаа илэрхийлж байж явцад бусад нь хүндэтгэлтэй, хүлээцтэй хандах ёстой.

Тухайлбал, тухайн хүний илэрхийлсэн үзэл бодол, дүгнэлттэй нь санал нэг байна уу, үгүй юу гэдэг асуудал огт хамаагүй юм. Оролцогч үгээ хэлж, санаалаа танилцуулж байх явцад бусад оролцогч чимээгүй байж саад учруулах ёсгүй. Үүнд гар утсаар ярих (сонсголын явцад гар утсаа унтраах буюу дууг нь хаах ёстой), эргэн тойрныхоо хүмүүстэй чангаар ярих, цаас шарчигнуулах, нааш цааш сэлгүүцэх, алга таших, хөлөө дэвслэх, шүгэлдэх, эсэргүүцэж хашгирах, үгийг нь тасалж тайлбар хийх зэргийг тэвчих хэрэгтэй.

Ээлж дугаараар үг хэлж, санаалаа танилцуулах. Хүн бүрийн хувьд цаг хугацаа үнэ цэнэтэй. Сонсголд оролцохын тулд бүх оролцогч цаг заваа золиослоход хүрдэг. Иймээс зарим оролцогч өөрийн цаг завыг бусдынхаас илүү үнэ цэнэтэй мэт үзэж индэрт гарах ээлж нь ирэхээс өмнө бусдын урдуур дайрч үг хэлж, санаалаа танилцуулах гэх нь шударга бус. Хүмүүс дарааллаа зөрчиж үг хэлэх нь бусад оролцогчдоо үл хүндэтгэсэнтэй адил төдийгүй сонсголын үйл явц, дэг журмыг алдагдуулах үр дагавартай. Ийм тохиолдолд хурал даргалагч үг хэлэх үйл явцыг зогсоон дахин дараалал тогтооход хүрдэг ба үүний улмаас хурлын үйл явц удааширч цаг хугацаа алддаг. Иймээс сонсголд үг хэлэх бүх хүнд адил тэгш боломж олгох, сонсгол саадгүй үргэлжлэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд оролцогчид тэвчээртэй байж үг хэлэх ээлжээ дэг журамтайгаар хүлээх хэрэгтэй.

Хэрэв гэнэтийн шалтгаанаар оролцогчид сонсгол дээрээс дуудагдан гарах болбол сонсголыг зохион байгуулж буй ажилтнуудтай ярьж үг хэлэх ээлжээ хойшлуулж, эргэж ирээд саналаа танилцуулах боломжтой эсэхийг асууж лавлаарай.

Ажлын хэсэг, байнгын хорооны гишүүддэд хүндэтгэлтэй хандах. Ажлын хэсэг, байнгын хорооны дарга, гишүүддэд хандаж үг хэлэхдээ тэдгээрийн албан ёсны нэр, албан тушаалаар нь (Хүндэт/эрхэм ажлын хэсгийн дарга, байнгын хорооны дарга, байнгын хорооны гишүүд г.м.) дуудах хэрэгтэй. Мөн энэ гарын авлагад өмнө дурдсанчлан ямар ч шалтгаантай байсан байнгын хороо, ажлын хэсгийн өмнө чангаар хашгирч ярих буюу бүдүүлэг үг хэллэг хэрэглэх ёсгүй.

Тухайлбал, оролцогч үг хэлж санал өгөхдөө сонсголын зар болон хуралдаан даргалагчийн хэлж сануулсан цагаас хэтрүүлэн яривал хурал даргалагч яриаг таслахад хүрдэг. Хэрэв ийм явдал тохиолдож оролцогч хэлэх үгээ дуусгалгүй төгсгөх шаардлага тулгарвал ажлын хэсэг, байнгын хороонд талархлаа илэрхийлээд тэдний зүгээс асуулт байвал хариулахад бэлэн гэдгээ хэлээд суудалдаа суух хэрэгтэй. Хурал даргалагч нь сонсголыг жигд тасралтгүй явуулж оролцож буй хүн бүрт тэгш боломж олгох үүрэгтэйг ойлгох нь чухал.

6.4 Үгээ хэлэх, саналаа танилцуулах

ИНДЭРТ ГАРАХ ЦАГ ИРЛЭЭ!

Оролцогчийг үгээ хэлнэ үү хэмээн индэрт дуудахад юуны өмнө боломжтой бол ажлын хэсэг, байнгын хорооны гишүүддэд олшуулж авчирсан саналаа тараан өгнө. Үүний дараа хурал даргалагч болон ажлын хэсэг, байнгын хороонд өөрийгөө танилцуулж, үг хэлэх боломж олгосонд талархаад саналаа танилцуулж эхэлнэ.

Оролцогчид үг хэлж, саналаа өгч байх явцдаа танхимд суугаа хүмүүсийн анхаарлыг татаж, өөртөө итгэлтэй байх ёстой. Хэрэв оролцогч үг хэлж, саналаа танилцуулж байх явцдаа ямар нэг алдаа гаргавал яриагаа таслахгүй, сандарч тэвдэхгүй байхыг хичээх нь зүйтэй.

Хүмүүс олны өмнө үг хэлэхдээ дууны өнгө, зогсолт, хөдөлгөөн, танхимд байгаа бусад хүн өөрийнх нь тухай юу гэж бодож байгаа талаар бодож

улам сандарч тэвдэж эхэлдэг. Тэд ийнхүү сандрахдаа хэлэх зүйлээ умартан ээрч түгдрэх, дуу нь намсах зэрэг алдаа гаргаж улмаар илтгэл нь тааруухан болж төгсдөг. Иймээс оролцогчид өөрсдөдөө бус, хэлж ярих зүйлдээ илүү анхаарах нь хамгийн чухал. Тухайн асуудал, эсвэл хуулийн төслийн талаар хангалттай судалж мэдээлэлтэй болсон өөртөө болоод ярьж буй зүйлдээ итгэл төгс байхад ийм алдаа гаргах нь ховор бөгөөд ямар ч үед ажлын хэсэг, байнгын хороонд асуудлаа ойлгуулж нөлөөлөхөд бүх хүч, анхаарлаа хандуулах ёстой.

Үгээ хэлж дууссаны дараа сонсгол зохион байгуулсан ажлын хэсэг, байнгын хорооныхонд дахин талархаж, гаргасан саналын талаар асууж тодруулах зүйл байвал хариулахад бэлэн байгаагаа илэрхийлснээр хурал даргалагчид яриагаа дуусгасан дохио өгнө. Асуулт гарвал өмнө өгүүлсэн зөвлөгөөг санан хариулах ба хурал даргалагч индрээс буухыг зөвшөөрсний дараа нэг бол суудалдаа буцаж суух буюу эсвэл танхимаас гарч явж болно.



6.5 Сонсгол зохион байгуулагчдын асуултын хэсэг

Сонсголд оролцогч хууль, шийдвэрийн төслийн талаарх саналаа ажлын хэсэг, байнгын хороонд танилцуулсны дараа ажлын хэсэг, байнгын хорооны зарим гишүүн тухайн оролцогчид асуулт тавьж хариулт авахыг хүсч болно. Асуултууд нь ихэнхдээ оролцогчийн хэлсэн үг, гаргасан саналыг тодруулах зорилготой байдаг. Энд онцлон дурдахад оролцогч сонсголоор яригдаж буй асуудлыг бүх талаас нь мэддэг байх, өөрт нь тавьсан асуултад аль болох хариулт өгөхийг хичээх нь чухал. Асуултад ийнхүү хариулах нь байр сууриа бататгах, өөрийнх нь саналтай холбоотой шийдвэр гаргагчдын эргэлзээг тайлах, итгэл үнэмшил төрүүлэх чухал боломж болохыг ойлгоорой.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:

Найм. Хэлэлцүүлгийн дэг

- 8.1. Оролцогчид байр сууриа илэрхийлж дууссаны дараа асуудал оруулагч талаас шаардлагатай гэж үзвэл оролцогчдод болон урилгаар оролцож буй гэрч, шинжээч, төрийн албан хаагч, судлаач, бусад зочдод хандан асуулт тавьж болно.

Асуулт хариултын үед дараахь зөвлөгөөг санаарай:

- **Тааж ярихгүй байх.** Ажлын хэсэг, байнгын хорооны тавьсан асуултад таамгаар эсвэл зохиож хариулах ёсгүй. Түүний оронд уг асуултын хариултыг сайн мэдэх хүн, мэргэжлийн байгууллагыг дурдсан нь дээр. Хэрэв оролцогч асуултад тэр дор нь шууд хариулах боломжгүй ч холбогдох мэдээлэл өөрт нь ойр байгаа бол тэр тухайгаа тайлбарлаж мэдэгдэх хэрэгтэй. Тухайлбал, “Энэ мэдээлэл манай ажил дээр байгаа, би сонсгол тарсны дараа явуулж болох уу?” гэх мэт.
- **Хариултдаа өөрийн гаргасан саналын чухал хэсгийг оруулж дурдах.** Асуулт нь зарим үед оролцогчид хуулийн төслийн талаар гаргасан саналынх нь гол хэсгүүдийг дахин хэлэх боломж олгох нь бий. Ийм боломж гарвал алдахгүйг хичээгээрэй. Жишээ нь: Энэ хууль иргэдийн эрхэд сөргөөр нөлөөлөхөөр байна гэж та хэллээ, үүнийгээ тодруулна уу? гэсэн асуултын хариуд өмнө илэрхийлсэн байр сууриа тодруулан жишээ баримт нэмж дурдах боломж байна.
- **Асуултын төрлүүд.** Оролцогчид сонсголын үеэр гарч болох асуултуудад хариулахад аль болох бэлтгэлтэй байх нь чухал. Ажлын хэсэг, байнгын хорооны гишүүдээс тавих асуултууд нь гол төлөв оролцогчийн баримталж буй байр суурь, төлөөлж байгаа байгууллага, гаргасан саналын шалгаан үндэслэл, хэлэлцэгдэж буй хуулийн төсөл эсвэл тухайн асуудлаарх мэдлэг туршлагын түвшинтэй холбоотой байдаг. Сонсголын үеэр түгээмэл тавигддаг асуултуудын жишээг доор үзүүлэв.

Энэ хуулийн төсөлд таны сая санаалдаа оруулж ярьснаас өөр ашиг тус, эсвэл хүндэрлтэй асуудал байгаа бол товч тайлбарлаж өгнө үү?

Энэ хуулийн төсөлтэй холбоотой мэдлэг туршлагынхаа талаар товч хуваалцана уу?

Энэ хуулийг сахиулах буюу хэрэгжүүлэхэд ямар нэг ноцтой хүндэрэл бэрхшээл гарна гэж та үзэж байна уу?

Энэ хууль өөр бусад хуультай зөрчилдөнө гэж та үзэж байна уу?

Энэ хуулийг тавьсан зорилгууддаа илүү сайн хүрэхүйц болгож сайжруулах, тийм нөхцөл бурдуулэхийн тулд та ямар засвар, нэмэлт өөрчлөлтийг санал болгомоор байна вэ?

Энэ хуулийг хэрэгжүүлэх зардлын талаар бие даасан судалгаа шинжилгээ байна уу?

6.6 Нээлттэй сонсгол зохион байгуулж буй байнгын хороо, ажлын хэсгийн нарийвчилсан хэлэлцүүлэг

Xүмүүс үгээ хэлж, асуулт хариулт явагдаж дууссаны дараа хуралдаан даргалагч хааж үг хэлснээр тухайн өдрийн сонсгол өндөрлөнө. Сонсголын төгсгөлд ажлын хэсэг, байнгын хороо заавал шийдвэр гаргах албагүй бөгөөд шийдвэр гаргахад харгалзан үзэх хангалттай мэдээлэл цуглуулж авах нь л сонсголын гол зорилго байдаг.

АНУ болон зарим улс оронд байнгын хороо, ажлын хэсэг сонсголын дараа шууд хуралдаж шийдвэр гаргах нь байдаг ба сонсголд ямар хүмүүс оролцож байгаа, хэр зэрэг эмзэг сэдвээр ярилцаж байгаагаас хамаарч хурал даргалагч оролцогчдыг танхимд үлдээж шийдвэр гаргахад байлцах боломж олгож болно. Хэрэв хурал даргалагч оролцогчийг үлдээхээр шийдсэн тохиолдолд үзэгчид чимээгүй суж, ажлын хэсэг байнгын хорооны шийдвэр гаргах хэлэлцүүлэгт саад учруулахгүйгээр оролцоно. Ялангуяа ажлын хэсэг, байнгын хорооноос гаргасан шийдвэрээ танилцуулах үед энэ дэгийг баримтлах ёстой.

Ихэнхдээ нээлттэй сонсголын дараа ажлын хэсэг, байнгын хороо шууд хуралдах боломж хомс байдаг. Учир нь хуулийн төслийн талаар иргэдийн гаргасан саналыг нэгтгэх, дун шинжилгээ хийж гарах шийдвэрт тусгахад тодорхой хугацаа шаардагддаг. Тухайлбал, Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар хэлэлцсэн хуулийн төслийг ийнхүү боловсруулж Ерөнхийлөгчид танилцуулахад хоёр долоо хоногийн хугацаа өгөхөөр журамд заасан байна.

7. СОНСГОЛЫН ДАРААХ АРГА ХЭМЖЭЭ

Баяр хүргэе! Та нээлттэй сонсголын үйл ажиллагаанд амжилттай оролцлоо. Тэгэхээр одоо энэ ажлынхаа үр дүнг баталгаажуулж юу хийж болох вэ? Хууль, шийдвэрийн төслийг судалж, санал боловсруулан сонсголд оролцсоноор гол ажлаа нугалаад авсан ч сонсголын дараа доор өгүүлсэн хэдэн зүйлийн зөвлөгөөг санаход илүүдэхгүй.

7.1 Тухайн асуудал, хууль тогтоомжид үргэлжлүүлэн хяналт тавих, туршлага багатай бусдадаа туслах

Нээлттэй сонсголын дараа хуулийн төсөл юу болов? Батлагдав уу, нэмэлт, өөрчлөлт оров уу? Таны хэлсэн үндэслэл, санал тусгагдаагүй бол ажлын хэсэг, байнгын хорооноос юуны учир тусгагдаагүй болохыг асуух эрх танд нээлттэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын журмаас:



Ес. Хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг шийдвэрт тусгах

- 9.1. Иргэний танхимын нээлттэй хэлэлцүүлгийн бүх хэлбэрээр санал авч дууссаны дараа төсөл боловсруулсан багийнхан төслийн эхийг хоёр долоо хоногт багтаан эцэслэн боловсруулж Ерөнхийлөгчид танилцуулна.
- 9.2. Иргэний Танхимд төслийн талаар ирүүлсэн бүх санал, тухайн санал төсөлд хэрхэн туссан, эс туссаныг тайлбарласан тайлбар бүхий хавсралттай төслийн шинэчилсэн хувилбарыг Иргэний Танхимын веб сайтад байрлуулна.
- 9.3. Энэ журмын 9.2 дахь заалтын дагуу боловсруулсан төслийг үндэслэн Ерөнхийлөгчийн гаргасан шийдвэр, УИХ-д өргөн барьсан хуулийн төслийг Иргэний Танхимын вебсайтад байрлуулна.
- 9.4. Энэхүү журам нь хүн бүрийн саналыг Ерөнхийлөгчийн шийдвэрт заавал тусгах үндэслэл болохгүй. Харин Ерөнхийлөгчийг шийдвэр гаргахаас өмнө иргэд байр суурь, саналаа чөлөөтэй илэрхийлж, сонсгох илүү өргөн боломж бий болгоход үйлчилнэ.

Зарим асуудал, хууль тогтоомжийн төслийг хэд хэдэн удаагийн сонсголоор хэлэлцэх шаардлагатай байдгийг энд бас санах хэрэгтэй. Ажлын хэсэг, байнгын хороо хоёр дахь сонсгол явуулахаар шийдсэн бол эхний сонсголд саналаа ирүүлсэн буюу танилцуулсан оролцогчдыг дахин оролцуулахаар урих нь бий. Түүнчлэн нээлттэй сонсголд оролцож үзсэн иргэдийн туршлага, тухайн хэлэлцэж буй асуудлын талаар мэдлэг нь туршлага, мэдээлэлтэй багатай бусад хүмүүст чухал эх сурвалж болдог.

7.2 Нээлттэй сонсголын үйл явцад туслалцаа үзүүлсэн хүмүүсдээ талархал илэрхийлэх

Оролцогчид нээлттэй сонсголд оролцох явцад дэмжлэг туслалцаа үзүүлсэн хүмүүс, төрийн болон төрийн бус байгууллагуудад талархал илэрхийлэх нь хожим дахиад нээлттэй сонсголд оролцох юмуу өөр ямар нэг зүйл дээр тэдний туслалцаа хэрэг болоход тустай байдаг.

7.3 Нээлттэй сонсголд оролцсон туршлагаасаа суралцах

Нээлттэй сонсгол бүрийн дараа оролцогчид хууль тогтоох үйл явцад эрхийнхээ дагуу оролцсон туршлага, үр дүнгээ эргэн харж суралцах нь чухал. Нээлттэй сонсголд анх удаа оролцсоны дараа энэ нь амаргүй агаад цаг хугацаа их шаардсан ажил мэт санагдаж болно. Үүнд шантрах хэрэггүй. Гарын авлагын эхэнд нэгэнтээ дурдсанчлан төрийн бодлогыг тодорхойлох гол арга зам болох хууль тогтоох явцад үзэл бодол, байр сууриа илэрхийлж идэвхитэй оролцох нь ардчилсан орны иргэн болохын хувьд таны эрх төдийгүй хүлээх нэг чухал үүрэг болохыг санан дараа дараагийн сонсголд түвэг чирэгдэл багатай, амжилттай, үр дүнтэй оролцоход юуг анхаарах нь зүйтэйг сайн эргэцүүлж бodoорой. Тухайлбал, дараахь асуултуудыг өөртөө тавиад үзэхэд гэмгүй. Үг хэлэхэд хангалттай бэлтгэлтэй байж чадав уу? Ажлын хэсэг, байнгын хорооноос тавьсан асуултуудад хариулж чадаж байсан уу? Тухайн үед мэдэж байх ёстой байсан авч мэдэхгүй байсан мэдээлэл байна уу?

Нээлттэй сонсгол бүрийг туршлага сууж суралцах боломж гэж үзсэнээр цааш цаашдаа оролцох бусад сонсголд хүчтэй, нөлөөтэй оролцогч болж чадна.





ХАВСРАЛТ

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын
2009 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн
20 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ТАНХИМЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон төрийн бодлого шийдвэрт иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах, иргэдийн санал бодлыг шийдвэр гаргагчид сонсох, олон нийтийн санаа зовоож буй асуудлаар нээлттэй хэлэлцэх зорилгоор байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний Танхимын (цаашид Иргэний Танхим гэх) үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Зорилго, үйл ажиллагааны зарчим

- 2.1. Иргэний Танхимын зорилго нь хуулийн төсөл, дүрэм журам, шийдвэрүүдийн төсөлд иргэд, байгууллагаас санал, шүүмжлэл, нэмэлт өөрчлөлтийн санаа, мэдээлэл хүлээн авах замаар төр засгийн түвшинд гарах шийдвэрийг сайжруулах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцуулах явдал юм.
- 2.2. Иргэний Танхимын бүх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байна.
- 2.3. Иргэний Танхимд болох аливаа хэлэлцүүлэг нь тодорхой шийдвэр, баримт бичгийн төслийг үндэслэн, шийдвэр гаргахын өмнөх шатанд явагдана. Төсөлд өөрчлөлт оруулах, төслийг шийдвэр болгон гаргахдаа Иргэний Танхимд болсон хэлэлцүүлэгт үндэслэнэ.

Гурав. Иргэний Танхимын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт

- 3.1. Иргэний Танхимын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нээлттэй хэлэлцүүлэг байна. Нээлттэй хэлэлцүүлэг нь оролцогч тал, асуудал оруулагч тал болон зохион байгуулагчаас тус тус бүрдэнэ.
- 3.2. Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогч нь Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл байна. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг хэлэлцүүлэг даргалагчийн урилгаар оролцуулж болно.
- 3.3. Нээлттэй хэлэлцүүлэгт асуудал оруулагч нь Ерөнхийлөгчийн зөвлөхүүд, Ерөнхийлөгчийн шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгүүд байна. Асуудал оруулж буй зөвлөл, ажлын хэсгийг ахалж буй ерөнхийлөгчийн зөвлөх, албан тушаалтан нь тухайн асуудлаар явагдаж буй нээлттэй хэлэлцүүлгийн даргалагч байна.
- 3.4. Иргэний Танхимын үйл ажиллагааг зохион байгуулагч нь Иргэний Танхимын Ажлын алба (Цаашид “Ажлын алба” гэх) байна. Ажлын алба нь нээлттэй хэлэлцүүлгийг олон нийтэд зарлах, иргэдээс санал мэдээлэл хүлээж авах, хэлэлцүүлгийг зохион байгуулах, хэвлэлээр мэдээлж сурталчлах, мэдээллийг цуглувж эмхэтгэх, саналыг ангилж бэлтгэх, асуудал оруулагч талын тайлан мэдээлэл бэлтгэх зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
- 3.5. Ажлын албаны бүтэц, орон тоог Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга батална.

Дөрөв. Иргэний Танхимд хэлэлцэх төслийг олон нийтэд зарлах

- 4.1. Нээлттэй хэлэлцүүлгийн даргалагч нь төслийн анхны эх, түүний товч агуулга, төслийн үндэслэлийн танилцуулгыг хэвлэл мэдээллээр зарлахаас ажлын гурав хоногийн өмнө Иргэний Танхимын Ажлын албанд хүлээлгэн өгнө.
- 4.2. Иргэний Танхимд хэлэлцэх төслийн анхны эх, хэлэлцүүлэг болох он сар өдөр, байр, цаг, үргэлжлэх хугацаа, иргэдийн санал хүлээж авах хаяг, электрон шуудан, лавлагaa авах, хэлэлцүүлэгт биечлэн оролцохоор бүртгүүлэх утасны дугаар, хаягийг дурдсан албан ёсны зарыг нээлттэй хэлэлцүүлэг болохоос гурван долоо хоногийн өмнө хэвлэл мэдээлэл, интернэтээр Ажлын алба зарлана.

Тав. Хэлэлцүүлэгт саналаа ирүүлэх

- 5.1. Хэлэлцүүлэгт оролцогч нь хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр хэлэлцүүлэг зарлагдмагц дараах хэлбэрээр санал шүүмжлэл, байр сууриа илэрхийлж болно. Үүнд:
 - 5.1.1. “Улаанбаатар, Төрийн ордон, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний Танхимд” гэж хаягласан захидааар;
 - 5.1.2. Иргэний Танхимд ирүүлсэн факсаар;
 - 5.1.3. Иргэний Танхимын irgen@president.mn электрон шуудангаар ирүүлсэн захидааар;
 - 5.1.4. www.president.mn веб сайтад санал ирүүлэх хэлбэрээр;
 - 5.1.5. Иргэний Танхимд болох хэлэлцүүлэгт биечлэн ирж оролцох хэлбэрээр.
- 5.2. Иргэний Танхимын нээлттэй хэлэлцүүлэгт өөрийн санал, байр суурийг томъёолоход хангалтгүй мэдээлэлтэй байна гэж үзвэл иргэд төсөл боловсруулагч нарт хандан асуулт тавьж, хариулт авч болно. Төсөл боловсруулагч нар асуултуудад Иргэний Танхимын хэлэлцүүлгийн үеэр хариулт өгнө.
- 5.3. Төсөл оруулж буй ажлын хэсэг төслийн талаар ирсэн саналыг нэгтгэж, ирсэн санал бүрийг тайлбарын хамт төсөлд хавсарган Иргэний Танхимын хэлэлцүүлэгт бэлтгэнэ. Иргэний Танхимын хэлэлцүүлэгт эхлэхээс өмнө төсөлд өөрчлөлт орсон бол уг ажлын хэсэг өөрчлөлтийн талаар хэлэлцүүлгийн эхэнд мэдээлэл хийж тайлбарлана.

Зургаа. Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчдод урьдчилсан болзол тавихгүй байх зарчим ба хэлэлцүүлэгт оролцох дараалал

- 6.1. Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчдод урьдчилсан болзол тавихгүй байх зарчим үйлчилнэ.
- 6.2. Иргэний Танхимын Ажлын алба нь зөвхөн хэлэлцүүлэгт биечлэн оролцохыг хүсэгчдийн дарааллыг тогтоох зорилгоор хэлэлцүүлэг болохоос ажлын гурав хоногийн өмнөх өдөр ажлын найман цагийн турш Иргэний Танхимын утас, факс, электрон шуудангийн хаягаар иргэдийн нэrsийг хүлээн авч бүртгүүлсэн цагийн дарааллаар жагсаана.

- 6.3. Ажлын алба нь бүртгэгдсэн нэrsийг нээлттэй хэлэлцүүлэг даргалагчид хэлэлцүүлэг эхлэхээс 48 цагийн өмнө танилцуулж, хэлэлцүүлэг даргалагчийн урилгаар оролцох хүмүүсийн нэrsийг хүлээн авна. Бүртгүүлсэн болон урилгаар оролцох нэrsийг жагсаалтын дагуу Иргэний Танхимын веб сайтад хэлэлцүүлэг эхлэхээс нэг хоногийн өмнө байрлуулна.
- 6.4. Нээлттэй хэлэлцүүлэг даргалагч нь оролцогчдын нэrsийн жагсаалт гарсны дараа дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж нээлттэй хэлэлцүүлэг болохоос нэг хоногийн өмнө хэвлэлээр мэдээлнэ. Үүнд:
- 6.4.1. Иргэний Танхимын хэлэлцүүлэгт оролцоо бүртгүүлсэн болон хэлэлцүүлэгт уригдсан хүмүүсийн нийт тоо Иргэний Танхимын суудлын тооноос илүүгүй тохиолдолд нээлттэй хэлэлцүүлгийг Иргэний Танхимын байранд энэхүү журмын дагуу зарласан цагт эхлүүлэх.
 - 6.4.2. Хэлэлцүүлэгт оролцоо илэрхийлсэн иргэдээс байрны багтаамжаас хамааран дараалуулж урилга олгоно. Шаардлагатай гэж үзвэл хэлэлцүүлгийг хэд хэдэн ээлжээр хийх буюу эсвэл өөр том байранд хийж болно.
- 6.5. Ижил байр суурьтай иргэд олноороо бүртгэгдсэн тохиолдолд иргэд дундаасаа төлөөлөл сонгож хэлэлцүүлэгт оролцуулж болно.
- 6.6. Хэлэлцүүлэгт үнэ цэнэтэй мэдээллээр хувь нэмэр оруулж чадах төрийн албан хаагчид, судлаач, шинжээч, гэрч, гадаадын болон судалгааны байгууллагын төлөөлөгчийг урилгаар оролцуулж болно.

Долоо. Хэлэлцүүлгийн бэлтгэл хангах

- 7.1. Иргэний Танхимд болох хэлэлцүүлгийн танхимыг бэлтгэх, хэлэлцүүлгийн үеийн протокол хөтлөх, хэлэлцүүлэг даргалагчийн хүсэлтээр хэлэлцүүлгийн дэг алдуулагчийг танхимаас гаргах, хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллээр дамжуулах, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг урьж оролцуулах ажлыг Ажлын алба хариуцна.
- 7.2. Хэлэлцүүлгийн үеэр аудио болон видео материал үзүүлж сонсгох, зураг, үзүүлэн таниулах материал байрлуулах, компьютерээр материал үзүүлж танилцуулах оролцогчдын материалыг

хэлэлцүүлэг эхлэхээс 1-2 цагийн өмнө Ажлын алба хүлээн авч техникийн бэлтгэл хангана.

- 7.3. Ажлын алба нь нээлттэй хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах, хэлэлцүүлэгт сэтгүүлч, сурвалжлагч, ажиглагч нарыг нэвтрүүлэх, тэдэнд суудал, байрлал хуваарилах зэрэг бэлтгэл ажлыг нээлттэй хэлэлцүүлэг эхлэхээс өмнө хийж гүйцэтгэнэ.
- 7.4. Хэлэлцүүлэгт оролцохоор ирсэн хүмүүсийг угтан авч, хэлэлцүүлгийн үеэр үг хэлэх дарааллыг тогтооход хэрэглэгдэх жагсаалт, бүртгэлийг хэлэлцүүлэг даргалагчийн гаргасан маягтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Найм. Хэлэлцүүлгийн дэг

- 8.1. Хэлэлцүүлэгт оруулж буй төслийн нэр, хэлэлцүүлэг зарласан огноо, хэлэлцүүлгийн танхимын зочдын тоо, хэлэлцүүлэгт асуудал оруулж буй төсөл боловсруулагч багийг Ажлын албаны ажилтан сонсгон танилцуулж хэлэлцүүлгийг нээнэ. Хэлэлцүүлгийг даргалах хүний нэр, албан тушаал, хэлэлцүүлэгт оролцож буй бусад албаны хүмүүсийг танилцуулна.
- 8.2. Даргалагч хэлэлцүүлгийн дэгийг оролцогчдод танилцуулан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хэлэлцэх асуудлын нарийн төвөгтэй байдлыг харгалзан хэлэлцүүлгийн нийт хугацаа, нэг оролцогчийн үг хэлэх хугацааг тус тус тогтооно. Ингэхдээ нэг хүний үг хэлэх хугацааг 3-10 минутаар тогтоож болно.
- 8.3. Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгох ба ингэхдээ нэг хүн А-4 хэмжээний бүтэн хуудас материал уншиж танилцуулж чадахуйц хэмжээгээр цаг олгоно.
- 8.4. Төсөл боловсруулсан багийн гишүүн оролцогчдод төслийг танилцуулна.
- 8.5. Оролцогчдын үг хэлэх дарааллыг хэлэлцүүлэг даргалагч тогтооно. Ингэхдээ энэ журмын 7.4 дэх заалтын дагуу бүртгүүлсэн нэrsийн дарааллыг үндэслэн дараахь дэс дарааллыг давхар баримтлан индэрт урина. Үүнд:

- 8.5.1. хөндлөнгийн шинжээч, эксперт, төрийн болон олон улсын байгууллагын холбогдох албаны хүмүүс үг хэлэх
- 8.5.2. төслийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг дэмжсэн байр суурьтай хүмүүс болон тэдгээрийн гэрч үг хэлэх
- 8.5.3. төслийг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг эсэргүүцсэн байр суурьтай хүмүүс болон тэдгээрийн гэрч үг хэлэх,
- 8.5.4. тайлбар, саналтай хүмүүс үг хэлэх.

Хэрэв төслийг дэмжсэн, эсэргүүцсэн, төсөлд санал тайлбар хийхийг хүссэн хүний тоо тус бүр 3-аас илүү бүртгэгдсэн бол тэдгээр байр суурьтай хүмүүс ээлжлэн үг хэлнэ.

- 8.6. Оролцогчид байр сууриа илэрхийлж дууссаны дараа асуудал оруулагч талаас шаардлагатай гэж үзвэл оролцогчдод болон урилгаар оролцож буй гэрч, шинжээч, төрийн албан хаагч, судлаач, бусад зочдод хандан асуулт тавьж болно.
- 8.7. Асуулт хариулт дууссаны дараа хэлэлцүүлэгт оролцогчид болон асуудал оруулагчдын зүгээс санал дүгнэлт хэлнэ. Ингэхдээ нэг хүнд нэг минутын хугацаа олгоно.
- 8.8. Хэлэлцүүлгийг даргалагч хэлэлцүүлгийг хааж үг хэлнэ.
- 8.9. Хэлэлцүүлэгт оролцогч зочин бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, яриаг нь таслах, өмнөөс нь үг хэлэх, хашгирах, шүгэлдэх, хөлөө дэвслэх зэрэг бусдад үгээ чөлөөтэй хэлэхэд нь саад учруулсан үйлдэл гаргавал хэлэлцүүлэг даргалагч дэг баримтлахыг шаардах бөгөөд шаардлагыг үл биелүүлбэл Иргэний Танхимиын Ажлын алба оролцогчийг танхимаас гаргаж болно.

Ес. Хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг шийдвэрт тусгах

- 9.1. Иргэний Танхимиын нээлттэй хэлэлцүүлгийн бүх хэлбэрээр санал авч дууссаны дараа төсөл боловсруулсан багийнхан төслийн эхийг хоёр долоо хоногт багтаан эцэслэн боловсруулж Ерөнхийлөгчид танилцуулна.
- 9.2. Иргэний Танхимд төслийн талаар ирүүлсэн бүх санал, тухайн санал төсөлд хэрхэн туссан, эс туссаныг тайлбарласан тайлбар бүхий

хавсралттай төслийн шинэчилсэн хувилбарыг Иргэний Танхимын веб сайтад байрлуулна.

- 9.3. Энэ журмын 9.2 дахь заалтын дагуу боловсруулсан төслийг үндэслэн Ерөнхийлөгчийн гаргасан шийдвэр, УИХ-д өргөн барьсан хуулийн төслийг Иргэний Танхимын вебсайтад байрлуулна.
- 9.4. Энэхүү журам нь хүн бүрийн саналыг Ерөнхийлөгчийн шийдвэрт заавал тусгах үндэслэл болохгүй. Харин Ерөнхийлөгчийг шийдвэр гаргахаас өмнө иргэд байр суурь, саналаа чөлөөтэй илэрхийлж, сонсгох илүү өргөн боломж бий болгоход үйлчилнэ.

Арав. Бусад зүйл

- 10.1. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зэрэг онцгой шаардлагын улмаас Иргэний Танхимд болох хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хойшлуулах буюу цуцалж болно. Хойшлогдсон хэлэлцүүлгийг зохион байгуулах тухай зарыг энэхүү журмын дөрөвдүгээр зүйлийн дагуу олон нийтэд мэдээлнэ.
- 10.2. Иргэний Танхимын хэлэлцүүлэг монгол хэл дээр явагдана.

----- *** -----